



СОНГУУЛИЙН
МАРГААНЫГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГААНЫ ЭРХЗҮЙН
ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ НЬ

ACCOUNTING

HOME

DEAL

INCOME

CHARGE

REPORTS

BUDGET

PROFILE

TOTAL

+ 23.12 m\$

- 0.065 m\$

+ 40.25 \$

+ 11.25 \$

- 05.75 \$

UPDATE





*Empowered lives.
Resilient nations.*

“Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” МОН 13/102 төсөл©

Тус судалгааг Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр бие даасан зөвлөх Н.Ариунболд, Б.Энхтөгс нар гүйцэтгэв.

Судалгаанд дурдагдсан дүгнэлт, зөвлөмж нь зохиогчийн байр суурь бөгөөд Монгол Улсын Их Хурал ба НҮБХХ-ийн байр суурийг илэрхийлэхгүй болно.

Энэхүү судалгааны тайланг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

“Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл
Монгол улс, 14201 Улаанбаатар хот, Төрийн ордон. Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1. Утас: +976-51-263143 splp.parliament.mn

НЭГ.ОРШИЛ

Хураангуй

Монгол Улсын шинэ Үндсэн хууль 1992 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр Улаанбаатар хотноо батлагдсанаас хойш даруй 22 жил өнгөрчээ. Энэхугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль гурван удаа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль хоёр удаа, орон нутгийн сонгуулийн тухай хууль гурван удаа тус тус шинэчилсэн найруулгын хэмжээнд батлагдаж Улсын Их Хурлын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгууль тус бүр долоон удаа явагдаж өнгөрчээ.

Сонгуулийн хуулиуд богино хугацаанд дахин дахин өөрчлөгдөж байдаг нь нэг талаас улс төрийн явцуу эрх ашигтай холбоотой байдаг боловч нөгөө талаас тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг зохицуулах харилцааны хувьд илүү боловсронгуй болгох улс төрийн хүсэл эрмэлзэлтэй мөн холбоотой байдаг билээ.

Монгол Улсад гурван төрлийн бүх нийтийн сонгууль явагддаг ба эдгээр сонгуулийг зохион байгуулах үндсэн баримт бичиг болох сонгуулийн хууль нь тус тусдаа байдгаас шалтгаалж хууль хоорондын зөрчилдөөн, эрхзүйн ойлголтын зөрүү байнга үүсдэг. Сонгуулийн хуулиудад ижил, төстэй харилцааг зохицуулсан зүйл заалтууд олон тоогоор байдаг, нэг ойлголтыг хуулиуд өөр өөрөөр зохицуулсан байдаг гэх мэт олон учир шалтгааны улмаас сонгуулийн хуулиудыг нэгтгэх, нэгдсэн ойлголттой болгох асуудал эрдэмтэн, судлаач, хуульч, улстөрчдийн дунд байнга яригддаг байсан билээ.

Харин энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс Улсын Их Хуралд “Сонгуулийн нэгдсэн хууль” төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Сонгуулийн хууль тогтоомжийн шинэчлэл, боловсронгуй болгох хүрээнд зайлшгүй тусгайлан авч үзэх асуудал бол сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхзүйн зохицуулалт юм.

Монгол Улсын Үндсэн хуульд сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц авч хэлэлцэх талаар зааснаас өөр тодорхой зохицуулалт төдийлөн байдаггүй. Харин сонгуулийн явцад сонгуулийн төв байгууллага болон бусад сонгуулийн байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагаа Үндсэн хуулиас бусад хууль тогтоомж зөрчсөн бол тухайн маргааныг хэн хянан шийдвэрлэх талаар сонгуулийн хуулиудад төдийлөн тодорхой бусад байдаг.

Урьд явагдаж байсан сонгуулийн үед үүсч байсан сонгуулийн маргаан, түүнийг хянан шийдвэрлэх явцыг харахад ихээхэн удаашралтай, зарим тохиолдолд

шийдвэрлэгдэхгүй ч байх үзэгдэл олонтой тохиолдож байсан.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явцыг ажиглахаар томилогдсон Олон улсын ажиглагчдын багийн хийсэн дүгнэлтэд маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалт сул байгаад шүүмжлэлтэй хандаж байсан.

Судалгааны зорилго

Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнөөс үүссэн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх эрхзүйн орчныг боловсронгуй болгох үүднээс дотоодын хууль тогтоомж, эрх зүйн актыг судлах, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх, өмнөх сонгуулийн явцад гарсан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн ажиллагааг харьцуулан үзэх, гадаад орнуудын туршлагыг харьцуулан судлаж үзсэний үндсэн дээр Улсын Их Хуралд байгуулагдсан сонгуулийн нэгдсэн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт судалгаа аргазүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж гаргах, оновчтой бодлогын хувилбар санал болгоход судалгааны ажлын зорилго оршсон.

Судалгааны хүрээ, хийгдсэн ажил:

Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрхзүйн орчинг боловсронгуй болгох судалгааны ажлын хүрээнд:

- Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнөөс үүссэн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэгдэж байгаа хууль тогтоомж, бусад эрх зүйн актын зохицуулалтын харилцаанд дүн шинжилгээ хийх.
- УИХ-ын 2008, 2012 оны сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009, 2013 оны сонгууль, 2008 оны Орон нутгийн Хурлын сонгууль, 2012 оны Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны сонгуультай холбогдон үүссэн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх.
- Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнөөс үүссэн хэрэг маргааныг түргэн шуурхай, ил тод, шударга, үр нөлөөтэй шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах санал боловсруулах.
- Гадаад орнуудын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэж байгаа сайн туршлага, түүний эрх зүйн зохицуулалтад харьцуулалт хийж, Монгол Улсад авч хэрэглэж болох хувилбарын талаар зөвлөмж боловсруулах.
- Судалгааны ажлын сэдвийн чиглэлээр өмнө нь хийгдэж байсан ижил, төстэй судалгааны ажлын мэдээллийн сан бүрдүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ач холбогдол

Энэхүү судалгааны дүнд маргаан шийдвэрлэх байгууллагын эрх мэдэл, харьяалал, холбогдох эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоог тодорхой болгож, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа түргэн шуурхай, ил тод, үр нөлөөтэйгээр шийдвэрлэгдэх санал боловсруулагдсан.

ХОЁР.ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа сонгуулийн хууль тогтоомжийг судлан үзэхэд Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гэсэн зургаан субектийн сонгуулийн үйл ажиллагааг зохицуулсан бие даасан 4 хууль өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна. Тухайлбал:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;
- Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль (цаашид эдгээр хуулийг сонгуулийн хуулиуд гэх).

Эдгээр хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаар гарсан маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд дээр дурдсан сонгуулийн хуулиудаас гадна дор дурдсан хууль тогтоомж хэрэглэгдэж байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль;
- Захиргааны хариуцлагын тухай хууль;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;
- Эрүүгийн байцаан шийтгэх хууль;
- Хууль тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн тогтоол;
- Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр.

Судалгааны ажлын 1 дэх даалгаврын дагуу эдгээр хууль тогтоомжид заасан, сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлын ерөнхий төлөвийг тоймлон харуулж, түүнд түүнд дүн шинжилгээ хийлээ.

Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэгдэх хуулийн зохицуулалтуудыг дор дурдсанаар тоймлон ангилж болохоор байна:

- Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх зарчим;
- Сонгуулийн маргааны төрөл;

- Сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан;
- Сонгуулийн хууль тогтоомжийн зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын асуудал.

Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх зарчим

Сонгуулийн үйл ажиллагааг зохицуулсан сонгуулийн хуулиудад:

“Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, нэр дэвшигч, сонгуульд оролцогч улс төрийн нам, хамтарсан намууд болон бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн үйл явцыг зохион байгуулах, түүнд оролцоходоо хууль дээдлэх; ил тод байдлыг хангах; шударга ёсыг сахих; маргааныг шуурхай, үндэслэлтэй, хуулийн хүрээнд шударга шийдвэрлэх; сонгогчдын эрх, сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хуулийн хариуцлага зайлшгүй хүлээлгэх; зарчмыг баримтална.” гэж заажээ.

Энэхүү зарчим нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий этгээдээс баримтлах тусгайлсан зарчим юм. Эдгээр зарчмыг нарийвчлан тусгаж өгснөөрөө зарим тохиолдол дахь хуулиар бүрэн гүйцэд тусгагдаагүй харилцаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд уг зарчмуудыг удирдлага болгон шийдвэрлэх боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Харин Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиудад маргаан шийдвэрлээд гаргасан шийдвэр нь үндэслэлтэй байх, хууль ёсны байх, маргаан шийдвэрлэх ажиллагаа хараат бус байх зэрэг хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмууд нь сонгуулийн маргааныг Үндсэн хуулийн цэц болон шүүхээр хянан шийдвэрлэхэд хамаарах зарчмууд юм.

Сонгуулийн маргааны төрөл

Судалгааны хүрээнд хамаарах сонгуулийн хууль тогтоомжуудыг судлан үзэхэд сонгуулийн маргааныг эрхзүйн үр дагавараар нь дор дурдсан байдлаар төрөлжүүлэн ангилж болохоор байна. Үүнд:

- Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх маргаан;
- Сонгох эрхтэй холбоотойгоор үүсэх маргаан;
- Сонгогдох эрхтэйгээр холбоотойгоор үүсэх маргаан;

- Сонгуульд оролцогч, нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнөөс үүсэх маргаан;
- Санал авах, санал хураалтын дүнг гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх маргаан;
- Сонгууль ажиглахтай холбогдсон маргаан;
- Сонгуулийн сурталчилгааны явц дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийн түгээж байгаа мэдээ, үйл баримттай холбоотой маргаан.

Харин маргаан үүсэх нөхцөл байдлаар нь дараах байдлаар ангилж болохоор байна. Үүнд:

- Сонгуулийн байгууллагын гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд холбогдсон гомдол;
- Сонгуулийн байгууллагаар хуульд нийцсэн шийдвэр гаргуулахтай холбогдсон маргаан;
- Эрхзүйн зөрчил үйлдэгдсэнтэй холбогдуулан зөрчлийг шалгах эрх бүхий этгээд нь бусдын гаргасан гомдлын дагуу болон өөр бие даан мөрдөн шалгахтай холбогдсон асуудал.

а/Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх маргаан

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх маргаанд сонгуулийн байгууллагуудын дотоод зохион байгуулалт, сонгууль зохион байгуулах талаар сонгуулийн байгууллагаас гаргаж байгаа гадагшаа чиглэсэн шийдвэр, үйл ажиллагаа, сонгуулийн байгууллагын албан тушаалтны сахилга баттай холбоотой үүссэн маргааныг хамааруулахаар байна.

Энэ төрлийн маргаан нь иргэний сонгох, сонгогдох эрхтэй шууд холбогдохгүй боловч сонгууль шударга, хуулийн дагуу нээлттэй, ил тод явагдахад нөхцлийг бүрдүүлэхтэй холбогдсон маргаан юм.

б/Сонгох эрхтэй холбоотойгоор үүсэх маргаан

Энэ төрлийн маргаан нь иргэний сонгох эрхтэй холбогдон үүсэх маргаан юм. Өөрөөр хэлбэл сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэх асуудал

юм. Учир нь сонгогч нь сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй бол сонгуульд оролцож саналаа гаргах боломжгүй байна. Сонгуулийн тухай хуулиудад зааснаар энэ төрлийн маргаанд сонгогчийн бүртгэлийн талаарх маргаан буюу сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, буруу бүртгэгдсэн, сонгогчийн шилжилтийг бүртгэхгүй байх зэрэг зөрчилтэй холбогдон үүссэн маргаан хамаарч байна.

Иргэний сонгуульд оролцох, цаашлаад сонгох эрхээ эдлэх гол үндсэн баталгаа нь өөрийн оршин суугаа газрын сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдэх явдал байдаг. Энэ эрхийг хангах зорилгоор сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргах болон хөндлөнгийн хяналтыг хангах зорилгоор сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуульд оролцож байгаа нам, эвсэлд танилцуулах, иргэдэд мэдээлэх харилцааг сонгуулийн хуулиудад нарийвчлан заажээ.

Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, буруу бүртгэгдсэн бол санал авах өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн холбогдох байгууллагад гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх зохицуулалт сонгуулийн хуулиудад нийтлэг байдлаар тусгагджээ. Уг маргаантай асуудлаар гомдол маргаан гаргах боломжийг тухайн сонгогчоос гадна түүний гэр бүлийн гишүүнд нь олгосон байгаа нь сонгогчийн сонгох эрх хэрэгжихтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх нэгэн онцлог зохицуулалт болон харагдаж байна.

Харин сонгогчдын нэрийн жагсаалтын талаар гомдол гаргах хугацааг “санал авах өдрөөс 10 хоногийн өмнө” гэж тогтоосон байгаа нь анхаарал татах ба хэрэв санал авах өдөр болоход 10 хоногоос бага хугацаа өнгөрсөн байвал сонгогч гомдол гаргаж асуудлаа шийдвэрлүүлж чадахгүйд хүрнэ. Энэ нь нэг талаас сонгогчдын нэрийн жагсаалт дахь маргаан шийдэгдэж дуусах, цаашлаад сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах хууль зүйн боломжит хугацааг хамгийн багадаа 10 хоног гэж тооцсонтой холбоотой байна.

Үүнээс гадна энд нэг зүйлийг зориуд дурдахад иргэний улсын бүртгэлд “сонгогчийн” гэсэн байнгын бүртгэлийг оруулахаар хуульчилсан нь энэ төрлийн маргаан тэр бүр нийтлэг гараад байхааргүй нөхцлийг бүрдүүлжээ. Учир нь тухайн хүн Монгол Улсын иргэн гэсэн бүртгэлтэй л бол иргэний улсын бүртгэлийн гадна үлдэх учиргүй юм.

в/Сонгогдох эрхтэйгээр холбоотойгоор үүсэх маргаан

Сонгуулийн хуулиудад зааснаар энэ төрлийн маргаанд нэр дэвшигчийг бүртгэхтэй холбоотойгоор үүсэх маргаан, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах, нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, түүний эрхийг хязгаарлах-тай холбогдон үүсэх маргаан хамаарахаар байна. Түүнчлэн энэ төрлийн маргаанд нам, эвслийн бүртгэлтэй

холбогдсон маргаан, цаашлаад хууль нам, эвслийг сонгуульд оролцоох эрхийг нь хязгаарлахтай холбогдсон маргаан мөн хамаарч байгаа болно. Учир нь нам гэдэг үзэл бодлоороо нэгдсэн улс төрийн зорилготой хуулийн этгээдээр дамжин түүнд нэгдсэн иргэний сонгогдох эрх хангагдаж байгаад оршино. Энэ төрлийн маргааныг шийдвэрлэх журмыг сонгуулийн хуулиудаар тодорхойлохдоо хууль өөрөөр заагаагүй бол доод шатны сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны талаар дээд шатны сонгуулийн хороонд гомдол гаргаж шийдвэрлүүлэх байдлаар журамласан байна. Түүнчлэн аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай маргааныг захиргааны хэргийн дагнасан шүүх шийдвэрлэж байхаар тусгагджээ.

г/Сонгуульд оролцогч, нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнөөс үүсэх маргаан

Үүнд сонгуулийн мөрийн хөтөлбөрт аливаа төрлийн мөнгө, эд хөрөнгө олгох, хувь хишиг хүртээх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэргээр амлалт тусгах, хуулиар хориглсон этгээдээс хандив авах, сонгуулийн сурталчилгааны үеэр хуульд хориглосон үйлдэл явуулах зэрэг зөрчил, ажиллагаатай холбоотойгоор үүссэн маргаан хамаарахаар байна. Энэ төрлийн маргааны онцлог нь өрсөлдөгч нам, эвсэл, нэр дэвшигчийн идэвхитэй гомдол саналын үндсэн дээр үүсч, шийдвэрлэгдэх ба эрхзүйн үр дагавар нь хууль зөрчсөн нэр дэвшигч болон нам, эвсэл нь захиргааны хариуцлагаас гадна нэрийн жагсаалтаас хасагдах хүртэл хариуцага хүлээдэгт оршино.

Сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн идэвхитэй гомдол санал гэдэг нь өрсөлдөгч нам, эвсэл, нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаар хасуулахаар гаргасан гомдол болон тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасахаар шийдвэрлэсэн сонгуулийн байгууллагын шийдвэрийг эсрэг гаргаж байгаа гомдол санал юм.

Энэ төрлийн маргаан нь захиргааны хариуцлага хүлээлгэх хуулийн санкцтай байдагтай уялдан энэ төрлийн маргааныг урьдчилж хэн шийдвэрлэх вэ гэдэг асуудлыг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл сонгуулийн хууль зөрчсөн эсэхийг хэн тогтоох вэ гэдэг дээр маргаан үүсдэг. Энэ зааг ялгаар сонгуулийн хуулиар нарийвчлан тусгаагүй байна. Иймд тухайн асуудлыг хуулиар тодорхой шийдвэрлэх шаардлагатай болно.

д/Санал авах, санал хураалтын дүнг гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх маргаан

Энэ төрлийн маргаанд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажиллагааг явуулах, санал, саналын хуудсыг хүчингүйд тооцох, санал хураалтын дүнг гаргаж, нэр дэвшигчийн үнэмлэх олгох, дахин сонгуултай холбогдсон зөрчил маргаан хамаарна.

е/Сонгууль ажиглахтай холбогдсон маргаан.

Энэ төрлийн маргаан нь нэг талаас ажиглагчийн үйл ажилагаатай холбоотой боловч нөгөө талаас ажиглагчийн шаардсанаар сонгуулийн үйл явцад гарсан сонгууль зохион байгуулалттай холбогдсон маргаан хамаарч байна.

ё/Сонгуулийн сурталчилгааны явцад сонгуулийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслийн түгээж байгаа мэдээ, үйл баримттай холбоотой маргаан.

Энэ төрлийн маргаан нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэн зөв мэдээлэл гарсан эсэх, сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийг гүтгэсэн, доромжилсон мэдээлэл гарсантай холбогдуулан үүсэх маргааны ойлгож болно. Энэ төрлийн маргааны талаар сонгуулийн зарим хуулиар тусгайлан заажээ. Маргааны үр дагаварт сонгогч сонголтоо хийхэд бодит мэдээлэл авах боломж гарах ба нам, эвсэл, нэр дэвшигчийн албаны болон хувийн нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалахад оршино.

Сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан

Сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан, тэдгээрийн эрх, үүрэг, үйл ажиллагааны хүрээ, хязгаарыг хариуцлагын төрлөөс нь хамаарч ялгавартай байдлаар тогтоожээ.

а/Захиргааны зөрчилд хариуцлага хүлээлгэх эрх бүхий этгээд

Энэ зохицуулалт нь МУИХ-ын сонгуулийн тухай хууль ба Нийслэлийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль ба Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд өөр өөрөөр заасан байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль ба Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулиуд нь УИХ-ын 2012 оны ээлжит сонгуулийн дараа шинээр батлагдсантай холбоотой ажээ. Өөрөөр хэлбэл МУИХ-ын сонгуулийн тухай хууль ба Нийслэлийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд тусгагдаагүй байсан шинэ зохицуулалтууд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль ба Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд туссан байна.

Захиргааны хариуцлага тооцох асуудал нь Захиргааны хариуцлагын тухай хуулиар нарийвчлан зохицуулагдах ба сонгуулийн хуулиудад зааснаар анхан шатны шүүхийн шүүгч захиргааны шийтгэлийг хүлээлгэнэ.

б/Эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх бүхий этгээд

Эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой асуудал нь сонгуулийн хуулиар зохицуулагдаагүй ба энэ нь зөвхөн Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу шийдэгдэнэ. Эдгээр хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг зөвхөн шүүх шийдвэрлэнэ.

в/Сонгуулийн хариуцлага хүлээлгэх эрх бүхий этгээд

Сонгуулийн хуулиудад зааснаар сонгуулийн байгууллагууд нь гишүүдээс бүрдэж, шийдвэр нь зөвхөн сонгуулийн байгууллагуудын хуралдааны үндсэн дээр гардаг. Иймд сонгуулийн хариуцлагыг сонгуулийн байгууллагын албан тушаалтан дангаараа шийдвэрлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл сонгуулийн хариуцлагыг зөвхөн сонгуулийн байгууллага хүлээлгэж маргааныг шийдвэрлэнэ.

Сонгуулийн хууль тогтоомжийн зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын асуудал.

Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд:

- эрүүгийн хариуцлага
- захиргааны зөрчлийн хариуцлага
- иргэний хариуцлага
- сонгуулийн хариуцлага хүлээлгэж болохоор хуульчлагджээ.

Эдгээр хариуцлагатай холбогдсон асуудал сонгуулийн хуулиудаар хэрхэн шийдвэрлэх боломжтой байгааг дор дурдсан байдлаар үзүүлвэл

Эрүүгийн хариуцлагатай холбоотой асуудлыг шийдвэрлэх зохицуулалт

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	МУИХ-ын сонгуулийн тухай хууль	Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль	Нийслэлийн ИТХ- ын сонгуулийн тухай хууль
--	--------------------------------------	---	---

<p>66.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</p>	<p>53.2.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>54.3.Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн... хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал уг асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль...д заасан журам, харьяаллын дагуу шийдвэрлэнэ.</p>	<p>59.4.Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал уг асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу шалган, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хянан шийдвэрлэнэ.</p> <p>58.2.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</p>	<p>50.2.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>51.3.Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн... тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал уг асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль...д заасан журам, харьяаллын дагуу шийдвэрлэнэ.</p>
---	---	---	---

Иргэний хариуцлагатай холбоотой асуудлыг шийдвэрлэх зохицуулалт

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	МУИХ-ын сонгуулийн тухай хууль	Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль	Нийслэлийн ИТХ- ын сонгуулийн тухай хууль
--	--------------------------------------	---	---

<p>66.3.Сонгуулийн үйл ажиллагааны явцад Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p>	<p>53.3.Сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>54.3.Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд ... иргэний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал уг асуудлыг... Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журам, харьяаллын дагуу шийдвэрлэнэ.</p>	<p>58.3.Сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд Иргэний хууль, бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>59.4.Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд... иргэний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал уг асуудлыг... Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хянан шийдвэрлэнэ.</p>	<p>50.3.Сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>51.3.Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд... иргэний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал уг асуудлыг... Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журам, харьяаллын дагуу шийдвэрлэнэ.</p>
--	---	--	--

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	МУИХ-ын сонгуулийн тухай хууль	Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль	Нийслэлийн ИТХ- ын сонгуулийн тухай хууль
--	--------------------------------------	---	---

<p>67.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар гаргасан сум, дүүрэг, хэсгийн хорооны шийдвэр, үйл ажиллагааны талаар аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэр, үйл ажиллагааны талаар Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргаж болох бөгөөд гомдол хүлээн авсан сонгуулийн хороо хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэй.</p>	<p>35.27.Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавьж, энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэнэ. 48.10.Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал тойргийн хороо санал авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ. 54.1.Энэ хуульд сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана.</p>	<p>59.1.Энэ хуульд сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана. 59.6.Сонгуулийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар гаргасан хэсгийн хорооны шийдвэр, үйл ажиллагааны талаар сум, дүүргийн сонгуулийн хороонд, сумын сонгуулийн хорооны шийдвэр, үйл ажиллагааны талаар аймгийн сонгуулийн хороонд гомдол гаргаж болох бөгөөд гомдол хүлээн авсан сонгуулийн хороо хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан</p>	<p>51.1.Энэ хуульд сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана. 52.1.Сонгуулийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар гаргасан хэсгийн хороо болон нийслэлийн тойргийн хорооны шийдвэрийн талаар Нийслэлийн сонгуулийн хороонд гомдол гаргаж болох бөгөөд Нийслэлийн сонгуулийн хороо гомдлыг хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.</p>
---	--	---	--

<p>67.3. Сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд тухайн гомдол, маргааны онцлог байдлыг харгалзан түргэн шуурхай шийдвэрлэнэ.</p>	<p>55.1.Хэсгийн хороо дараах гомдол, маргааныг хүлээн авч шийдвэрлэнэ: 55.1.1.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан сонгогчийг нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэн тухай гомдол; 55.1.2.ажиглагч энэ хуулийн 44.6-д заасан зөрчил гаргасан тухай татгалзсан асуудлаар гаргасан гомдол, маргаан; 57.1.4.нам, эвслийн тойрогт нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах асуудлаар гаргасан гомдол, маргаан; 57.1.5.энэ хуулийн 56.1-д заасан гомдол, маргааныг хянан шийдвэрлэсэн тойргийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдол; 57.1.6.Сонгуулийн ерөнхий хорооны эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэртэй холбогдох гомдол, маргаан. 57.2. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 57.1.1-57.1.4-т заасан гомдол, маргааныг нэн даруй, гэхдээ хүлээн авснаас</p>	<p>шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэй. 59.7. Аймаг, сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэр хууль зөрчсөн эсэх маргааныг эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээдийн гомдол, нэхэмжлэлийг санал авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор тухайн нутаг дэвсгэрийн харьяалах захиргааны хэргийн шүүх хүлээн авч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ. 59.8. Шүүх сонгуулийн хорооны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэхийг хориглоно. 59.9.Энэ хуулийн 59.7-д заасан хугацаа хэтэрсэн бол Захиргааны хэргийн шүүх</p>
---	---	---

	<p>гомдол.</p> <p>55.2.Хэсгийн хороо энэ хуулийн 55.1.1-д заасан гомдлыг улсын бүртгэлийн холбогдох байгууллагад ажлын хоёр өдрийн дотор мэдэгдэх, энэ хуулийн 55.1.2-т заасан гомдлыг ажлын хоёр өдрийн дотор, санал авах өдрийн өмнөх өдөр гомдол гаргасан бол тухайн өдөрт нь багтаан шийдвэрлэж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авна.</p> <p>56.1.Тойргийн хороо дараах гомдол, маргааныг хянан шийдвэрлэнэ:</p> <p>56.1.1.энэ хуулийн 55.1-д заасан гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн хэсгийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдол;</p> <p>56.1.2.энэ хуульд заасан үндэслэлээр нэр дэвшигчийг бүртгэсэн болон бүртгэхээс татгалзсан асуудлаар гаргасан гомдол, маргаан;</p> <p>56.1.3.энэ хуулийн 35.18, 35.22-т заасан үйлдэл, үйл ажиллагаа явуулсан тухай мэдээлэл, гомдол;</p> <p>56.1.4.энэ хуулийн 39.7, 39.8-д заасныг зөрчсөн</p>	<p>нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.</p> <p>59.10.Сонгуулийн маргаан хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд нь тухайн маргааны онцлог байдлыг харгалзан түргэн, шуурхай шийдвэрлэнэ.</p>	
--	---	--	--

	<p>55.1.2-т заасан гомдлыг ажлын хоёр өдрийн дотор, санал авах өдрийн өмнөх өдөр гомдол гаргасан бол тухайн өдөрт нь багтаан шийдвэрлэж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авна.</p> <p>56.1.Тойргийн хороо дараах гомдол, маргааныг хянан шийдвэрлэнэ:</p> <p>56.1.1.энэ хуулийн 55.1-д заасан гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн хэсгийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдол;</p> <p>56.1.2.энэ хуульд заасан үндэслэлээр нэр дэвшигчийг бүртгэсэн болон бүртгэхээс татгалзсан асуудлаар гаргасан гомдол, маргаан;</p> <p>56.1.3.энэ хуулийн 35.18, 35.22-т заасан үйлдэл, үйл ажиллагаа явуулсан тухай мэдээлэл, гомдол;</p> <p>56.1.4.энэ хуулийн 39.7, 39.8-д заасныг зөрчсөн тухай мэдээлэл, гомдол;</p> <p>56.1.5.тойрогт нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах асуудлаар гаргасан гомдол, маргаан;</p>		
--	---	--	--

	<p>хойш гурав хоногийн дотор, энэ хуулийн 57.1.5, 57.1.6-д заасан гомдол, маргааныг нэн даруй, гэхдээ хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тус тус хянан шийдвэрлэнэ.</p> <p>57.3.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 57.1-д заасан асуудлаар шийдвэр гаргана.</p> <p>57.4.Сонгуулийн ерөнхий хороо шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 57.1-д заасан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх хүртэл хугацаанд доод шатны сонгуулийн хорооны шийдвэрийг түдгэлзүүлэх эрхтэй.</p> <p>58.1.Хуульд өөрөөр заагаагүй бол сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар гаргасан хэсгийн болон салбар хорооны шийдвэрийн талаар тойргийн хороонд, тойргийн хорооны шийдвэрийн талаар Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны хороо гомдлыг хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.</p>		
--	--	--	--

ГУРАВ.ТОХИОЛДОЛ СУДАЛГАА

Судалсан байдал:

2008-2012 онд явагдсан сонгуулиар үүссэн зарим хэрэг, маргааны шийдэгдсэн байдлыг судлан үнэлэлт дүгнэлт өглөө. Судалгааны обект нь “сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнөөс үүссэн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох” асуудал тул уг шийдвэрүүдийн агуулгад буюу зөв, буруу эсэхэд дүгнэлт хийгээгүй болно. Харин тухайн маргаантай асуудлыг ямар журмаар, яаж шийдвэрлэсэн бэ гэдгийг судлан, үнэлэлт дүгнэлт өглөө. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдсон маргаантай асуудлаар гарсан, шийдсэн шүүхийн шийдвэр гараагүй байна.

Судалгаанд 2008-2013 онд явагдсан сонгуулиудаар үүсэж байсан зарим маргаан зөрчилтэй тохиолдол багтсан ба тухайн хугацаанд сонгуулийн хуулиуд шинэчилсэн найруулга хэлбэрээр шинээр батлагдсаны улмаас 2012, 2013 онд явагдсан сонгуулиуд сонгуулийн шинэ хуулийн дагуу явагджээ.

Өөрөөр хэлбэл УИХ-ын 2008 оны сонгууль нь 2005.12.29-нд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу явагдсан бол 2012 оны сонгууль нь 2011.12.15-нд батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны сонгууль нь 1993.02.15-нд батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу явагдсан бол 2013 оны сонгууль нь 2012.12.21-нд батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2008 оны сонгууль нь 2007.01.18-нд батлагдсан Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу явагдсан бол 2012 оны сонгууль нь 2012.04.27-нд батлагдсан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон 2012.09.14-нд батлагдсан Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу тус тус явагджээ.

Иймд тухайн үед үүсэж байсан тохиолдол /кейс/ бүрийг хүчин төгөлдөр үйлчилж байсан хуультай нь холбогдуулан авч үзлээ. Тохиолдол тус бүрийг товчлон хавсралтадад жагсаан бичсэн болно.

Тохиололд 1.

УИХ-ын 2008 оны сонгуулийн 4-р тойрогт үүссэн сонгуулийн маргаантай асуудал.

2008.07.04, 2008.07.10-ны өдөр УИХ-ын 2008 оны сонгуулийн 4-р тойргийн хороо Х намаас нэр дэвшигч М, Ц нар МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалт зөрчсөн эсэх маргааныг авч хэлэлцэн, нэр дэвшигч Ц-г нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасахаар шийдвэрлэжээ. Гэтэл тойргийн хорооны дарга Д нь тойргийн хорооны хуралдаанаас гарсан шийдвэрээс өөр агуулгатай тогтоолыг албажуулж гарган СЕХ-нд хүргүүлсэн байна. Харин СЕХ-ноос “маргаантай асуудлаа хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүл” гэсэн хариуг өгснөөр сонгуулийн маргаан үүссэн байна.

Тиймээс гомдогчид маргаантай асуудлаараа Булган аймгийн сум дундын шүүхэд хандсан байх ба анхан шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон боловч давж заалдах болон хяналтын шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилж хэргийг хэрэгсэхгүй болгож сонгуулийн маргаантай асуулыг шийдвэрлэхээс татгалзжээ. Шүүхийн шийдвэрийн үндэслэл нь Үндсэн хуулийн цэцийн 2005.03.31-ний өдрийн №02 дүгнэлт, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2.2, МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн /2005/ 19.10, 57.5 заалт болсон байх ба утга нь “нэхэмжлэгч тал тухайн маргаантай асуудлаар буюу тойргийн хорооны шийдвэрийн талаар СЕХ-нд гомдол гаргаж шийдвэрлүүлсний дараа Үндсэн хуулийн цэцэд хандах эрхтэй” гэж үзжээ.

Дүгнэлт:

Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1.4-т зааснаар Улсын дээд шүүх нь Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах эрхтэй байдаг. Түүнчлэн Улсын дээд шүүх нь хэрэг маргааныг хяналтын журмаар шийдвэрлэж, практик тогтоох замаар хууль тайлбарлах эрхээ хэрэгжүүлдэг.

Тухайн тохиолдолд Улсын дээд шүүх нь иргэний сонгох, сонгогдох эрх зөрчигдсөн тухайн маргааныг шүүх /үүний дотор дагнасан шүүх/ бус Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ гэж тогтоосон байна.

Өөрөөр хэлбэл УИХ-ын сонгуулийн тойргийн хорооны шийдвэр хууль зөрчсөн эсэх асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн тал СЕХ-нд гомдол гаргах ба гомдлыг СЕХ шийдвэрлэнэ. Үүний дараа буюу тухайн асуудлаар СЕХ-ноос гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдогч тал СЕХ-нд холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргаж маргаанаа нэг мөр шийдвэрлүүлэх ёстой гэсэн хууль хэрэглээний жишгийг Улсын дээд шүүх тогтоожээ.

Дээрхи тохиолдолтой холбогдон дараах ойлгомжгүй эрхзүйн нөхцөл байдал ажиглагдлаа.

Үүнд:

- Сонгуулийн тогтолцооны байгууллага болох сонгуулийн хэсгийн хороо, салбар хороо, тойргийн хороо, ерөнхий хороо нь тус бүрдээ эрхзүйн хувьд нэг бүхэл байгууллага уу, бие даасан байгууллагууд уу гэдэг асуудал тодорхойгүй байна. МУИХ-ын сонгуулийн тухай хууль /2005/-д зааснаар сонгуулийн орон нутгийн байгууллага нь эрхзүйн хүрээнд шийдвэр гаргах эрхтэй, бие даасан байгууллага байхаар зохицуулагдсан авч Улсын дээд шүүхийн тогтоосноор шүүхэд хариуцагч байх эрхзүйн чадваргүй гэж үзжээ. Иргэний хэрэг шүүхэд шийдвэрлэх болон захиргааны хэрэг шийдвэрлэх эрхзүйд шүүхээс урьдчилан шийдвэрлэх журам байдаг. Энэхүү журмын дагуу бол маргаан бүхий шийдвэр гаргасан этгээдийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдогч тал эхлээд маргааныг шийдвэрлэх эрх бүхий /дээд шатны/ этгээдэд хандаж гомдлоо шүүхээс урьдчилан шийдвэрлүүлнэ. Харин эрх бүхий этгээд гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг нь гомдогч эс зөвшөөрсөн, түүнчлэн эрх бүхий этгээдийг гаргасан шийдвэрийг анх маргаан бүхий шийдвэр гаргасан этгээд биелүүлээгүй тохиолдолд гомдогч анх маргаан гаргасан этгээдэд нь холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой байдаг. Гэтэл дээрхи тохиолдолд УИХ-ын сонгуулийн тойргийн хороо маргаан бүхий шийдвэр гаргаад байхад тухайн маргаантай холбоотой асуудлаар СЕХ-нд холбогдуулан шүүхэд /Цэцэд/ гомдлоо гаргаж шийдвэрлүүл гэсэн Улсын дээд шүүхийн “шийдэл” эрхзүйн хувьд ойлгомжгүй байна.

- Үндсэн хуулийн цэц нь зөвхөн иргэний өргөдөл, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэдэг. Хэрэв тухайн маргаантай асуудлаар хандах этгээд нь хуулийн этгээд /нам, эвсэл/ байгаа тохиолдолд хүлээн авч шийдвэрлэх эсэх нь тодорхойгүй үлдэж байна. Өөрөөр хэлбэл тухайн тохиолдол хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн бол зөрчигдсэн эрхээ хэрхэн сэргээлгэх нь тодорхойгүй байна.

- Дээрхи тохиолдолд СЕХ 2008.07.28-ны өдрийн 413 албан тоотоор гомдол гаргагчид гомдлынх нь хариуг өгсөн байхад тухайн маргаантай асуудлыг СЕХ шийдвэрлээгүй байна гэсэн Улсын дээд шүүхийн дүгнэлт нь мөн л ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл УИХ-ын сонгуулийн тойргийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдлыг СЕХ шийдвэрлэхгүй орхигдуулсан тохиолдолд гомдол гаргагч хэнд хаашаа хандах нь тодорхойгүй үлдэж байна.

Тохиололд 2.

УИХ-ын 2008 оны сонгуулийн 24-р тойрогт үүссэн сонгуулийн маргаантай асуудал.

УИХ-ын 2008 оны сонгуулийн 24-р тойрогт нэр дэвшигч О, Б, Г нар сонгуулийн санал тооллого буруу явагдсан гэж үзэн “дахин санал тоолуулах” тухай гомдлыг тойргийн хороонд гаргасан боловч тойргийн хороо гомдлыг шийдвэрлээгүй байна. Тойргийн хороо гомдлыг шийдвэрлэхгүй байсан тул уг асуудлаараа гомдогчид СЕХ-нд хандсан боловч мөн л шийдвэрлэлгүй өнгөрчээ. Нэгэнт сонгуулийн байгууллагууд гомдлыг үл шийдвэрлэсэн тул гомдогчид Чингэлтэй дүүргийн шүүхэд хандаж нэхэмжлэл гаргасан боловч Чингэлтэй дүүргийн шүүгч А “хуульд заасан журмыг зөрчиж ирүүлсэн” буюу гомдлыг СЕХ, цаашлаад Үндсэн хуулийн цэц шийдвэрлэх хуультай гэж үзээд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ.

Тухайн маргаантай асуудлыг сонгуулийн байгууллагууд болон шүүх хүлээн авч шийдвэрлэхгүй байсан тул гомдогчид Үндсэн хуулийн цэцэд хандсан боловч Цэцээс “Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд зааснаар СЕХ-ны шийдвэр тогтоол хэлбэртэй байх шаардлагатай, маргаж байгаа асуудлаар СЕХ-ны тогтоол гараагүй, СЕХ-ны үйл ажиллагааг Цэц хянахгүй гэж үзээд өргөдлийг буцаан Цэцийн гишүүний тогтоол, Цэцийн магадлал гаргасан байна.

Нэр дэвшигч санал дахин тоолохтой холбогдсон гомдлыг 2010.07-р сард дахин Чингэлтэй дүүргийн шүүхэд гаргасан боловч тойргийн хороо татан буугдсан, тойргийн хорооны шийдвэр байхгүй гэсэн үндэслэлээр мөн л хүлээн авахаас татгалзжээ.

Дүгнэлт:

Дээр дурдсан шүүхийн шийдвэрээс үзэхэд УИХ-ын сонгуулийн тойргийн хороо, цаашлаад СЕХ-ны үйлдэл, эс үйлдэхүй нь хуулийн /шүүхийн/ хяналтгүй болсон байгааг илтгэнэ. Сонгуульд оролцогч этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалуулж, маргааныг шийдвэрлүүлэхээр сонгуулийн байгууллагад ханддаг боловч гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэхгүй орхигдуулах, эсхүл хуульд заасан хэлбэрээр бус байдлаар шийдвэрлэснээр асуудал шийдвэрлэгдэхгүй өнгөрч болохоор байна. Үндсэн хуулийн цэц нь “УИХ-ын сонгуулийн талаар гаргасан СЕХ-ны шийдвэр Цэцийн харьяаллын маргаан гэж дүгнэсэн” байдаг боловч эргээд СЕХ-ны тогтоолоос бусад шийдвэрийг бид хянахгүй гэж үздэг нь “...тэгээд СЕХ болон сонгуулийн орон нутгийн байгууллагын тогтоолоос бусад шийдвэр, үйл ажиллагааг хэн хянах вэ” гэсэн эрхүйн тодорхойгүй үр дагаварыг үүсгэж байна.

Тохиолдол 3.

УИХ-ын 2008 оны сонгуулийн үеэр үүссэн СЕХ-ны даргын хууль бус үйл ажиллагаанд холбогдсон маргаантай асуудал.

УИХ-ын 2008 оны сонгуулийн өдөр буюу 2008.06.29-ний өдөр СЕХ-ны дарга Д.Баттулга нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр “сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдээгүй боловч иргэний үнэмлэхтэй иргэдийг тухайн хэсэгт нь сонгууль өгүүлж болно” гэсэн мэдэгдлийг хийн, албан тоотыг сонгуулийн орон нутийн байгууллагуудад илгээжээ.

СЕХ-ны даргын дээр дурдсан шийдвэр, үйл ажиллагаа нь МУИХ-ын сонгуулийн тухай хуульд заасан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, түүнд гомдол гаргаж шийдвэрлүүлэх журмыг зөрчсөн гэж үзээд нэр дэвшигч Б нь шүүхэд хандсан боловч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж Чингэлтэй дүүргийн шүүгчийн захирамж, тогтоол,

захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, Улсын дээд шүүхийн магадлал тус тус гарчээ.

Нэгэнт шүүхүүд уг маргааныг хэргийн харьяаллын бус үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан тул нэхэмжлэгч хэргийн харьяалал тогтоолгохоор Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргасан байна. Гомдлыг хүлээн авсан Цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхгүйгээр Улсын дээд шүүхээс тайлбар гаргуулан, тухайн асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзэн Улсын дээд шүүхэд шилжүүлжээ. Харин Улсын дээд шүүхээс, тухайн асуудлаараа нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу Чингэлтэй дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой байна гэсэн хариуг нэр дэвшигчид өгснөөр нэхэмжлэгч Чингэлтэй дүүргийн шүүхэд нэхэмжлэл гарган маргаанаа шийдвэрлүүлжээ.

Дүгнэлт:

Сонгуулийн байгууллагын албан тушаалтан хууль зөрчсөн улмаас бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэх маргааныг хэн шийдвэрлэх талаар хуульд тусгайлан заагаагүйн улмаас шүүхүүд тухайн маргаантай асуудлыг хүлээн авахаас татгалзаж байжээ. Ийнхүү татгалзснаар Монгол Улсын иргэний Үндсэн хуулиар баталгаажсан нь шүүхэд гомдол гаргах эрх мөн зөрчигдөхөд хүрсэн байна. Харин тухайн тохиолдолд хэргийн харьяаллын талаар нэхэмжлэгч Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргаж шийдвэрлүүлсний үндсэн дээр шүүхэд гомдол гаргах эрхээ нээлгэж, гомдолтой байгаа асуудлаа шийдвэрлүүлж чаджээ. Гэсэн хэдий боловч тухайн тохиолдолд нэхэмжлэгч маргаанаа өөртөө ашигтай шийдвэрлүүлж чадсан ч “сонгогдох” эрх нь ямар нэг байдлаар сэргээгдээгүй үлджээ. Үүнээс дүгнэхэд МУИХ-ын сонгуулийн тухай хуульд ямар маргааныг аль шүүхээр шийдвэрлэх талаар хуульд тусгайлан заагаагүй нь нэхэмжлэгчид ихээхэн хүндрэл учруулж байсан нь харагдаж байна.

Тохиолдол 4.

УИХ-ын 2012 оны сонгуулийн 3-р тойрогт үүсэн маргаантай асуудал.

УИХ-ын сонгуулийн 3-р тойрогт Х намаас нэрдэвшсэн 3-р сонгуулийн сурталчилгааны үеэр хууль зөрчсөн гэж үзэн өрсөлдөгч нэг намаас нь тойргийн хороонд гомдол гаргажээ. Гомдлыг хүлээн авсан тойргийн хороо нэр дэвшигч 3 үйл ажиллагаа нь хууль зөрчөөгүй байна гэсэн хариуг өгсөн тул гомдол гаргагч нь СЕХ-нд давж заалджээ. Гэвч СЕХ нь МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 57.1-д заасны дагуу гомдлыг гурав хоногийн дотор шийдвэрлээгүй гомдогч аймгийн захиргааны хэргийн шүүхэд хандсан байна. Нэхэмжлэлийг хүлээн авсан захиргааны хэргийн шүүх “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.6-д Сонгуулийн Ерөнхий хороо гэж байсан нь хүчингүй болсон тул сонгуулийн маргааныг хүлээн авах боломжгүй” гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шүүгчийн захирамж гаргажээ. Уг захирамжид гомдол гаргасан боловч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийн үндэслэх хэсгийн өөрчилж буюу “аймгийн нам гэсэн хуулийн этгээд байхгүй тул аймгийн намын дарга нь намыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд” гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

Дүгнэлт:

2011 онд МУИХ-ын сонгуулийн тухай хууль шинэчлэн батлагдсан боловч тохиолдол 1, 2-т дурдагдсан Үндсэн хуулийн цэцийн 2005.03.31-ний өдрийн №02 дүгнэлттэй холбоотой асуудал энэ тохиолдол дээр мөн дурдагдаж байна.

Гомдол гаргагч хариуцагчаа тойргийн хороо гэж тодорхойлсоор байхад аймагийн захиргааны хэргийн шүүх СЕХ-нд холбогдуулан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь ойлгомжгүй. Харин анхан шатны шүүхийн энэ ойлгомжгүй байдлыг давж заалдах шатны шүүх өөрчилсөн боловч нэхэмжлэл гаргах эрхгүй этгээдийн нэхэмжлэл гаргасан гэж үзээд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг хэвээр үлдээжээ.

Үүнээс үзэхэд захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн дагуу бол тойргийн хорооны бүрэн эрхийн асуудлаар тойргийн хороо гэх байгууллагад холбогдуулан сонгуулийн маргаантай асуудлаар захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлэх боломжтой байна.

Тохиолдол 5.

УИХ-ын 2012 оны сонгуулийн 26-р тойрогт үүсэн маргаантай асуудал.

УИХ-ын 2012 оны сонгуулийн 26-р тойрогт нэр дэвшигч Э нь өөрийн нэр дэвшсэн тойргийн санал хураалтын нэгдсэн дүн нь хууль зөрчиж буруу гарсан гэж үзэн тойргийн хороотой сонгуулийн маргаан үүсгэжээ. Нэр дэвшигч Э нь тойргийн хорооны гаргасан шийдвэрийн талаар СЕХ-нд давж заалдан гомдол гаргасан боловч хуульд заасан хугацаанд гомдлыг шийдвэрлээгүй орхигдуулжээ. Иймд тэрбээр шууд харьяалах дээд шатны байгууллага нь хуульд заасан хугацаанд гомдлыг шийдвэрлээгүй бол анх шийдвэр гаргасан байгууллагад нь холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргадаг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх эрхзүйн нийтлэг зарчмын дагуу захиргааны шүүхэд хандсан байна. Уг нэхэмжлэлийг анхан шатны захиргааны хэргийн шүүх хүлээн авахаас татгалзсан боловч, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон, хүлээн авч шийдвэрлэхээр болжээ. Улмаар уг маргаан Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүхээр эцэслэн шийдэгдсэн байна.

Дүгнэлт:

Сонгуулийн маргаан нь сонгуулийн орон нутгийн болон төв байгууллага ба сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигч цаашлаад сонгогч иргэний хооронд буюу захиргаа ба иргэн /нам, эвсэл/-ий хооронд үүсдэг. Хэрэв сонгуулийн байгууллагууд хууль зөрчсөн шийдвэр, үйл ажиллагаа явуулсан бол зөрчлийг арилгуулж зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалуулахаар гомдол гаргах эрх нь иргэн, хуулийн этгээдийн шүүхэд мэдүүлэх үндсэн эрх юм.

Гэтэл СЕХ-ны шийдвэрийн талаархи маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болсон байгааг дээрхи тохиолдол мөн харуулж байгаа ба харин сонгуулийн орон нутгийн байгууллагад холбогдох маргааныг захиргааны хэргийн дагнасан шүүх хүлээн авч шийдвэрлэх боломжтойг энэ тохиолдол нотолж байна. МУИХ-ын сонгуулийн тухай хуульд сонгуулийн төв болон орон нутгийн байгууллагад холбогдох маргааныг аль шүүх шийдвэрлэх талаар тодорхойлон дурдаагүй боловч ямартай ч захиргааны хэргийн дагнасан шүүх процессийн эрхзүйн ерөнхий зарчмаа барин сонгуулийн орон нутгийн байгууллагад холбогдсон маргааныг хүлээн авч шийдвэрлэх боломжтой байгааг энэ тохиолдол харуулж байна.

Тохиолдол 6.

УИХ-ын 2012 оны сонгуулийн 15-р тойрогт үүсэн маргаантай асуудал.

УИХ-ын 2012 оны сонгуулийн 15-р тойрогт нэр дэвшигч Х, Ч нарыг сонгуулийн сурталчилгааны явцад хууль зөрчсөн гэж үзэж тэдгээрийг нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасуулах асуудлаар тойргийн хороонд гомдол гаргажээ.

Гэвч тойргийн хороо нь нэр дэвшигч Х, Ч нар сонгуулийн хууль зөрчөөгүй гэж үзэн нэр дэвшигч М, Н нарын гомдлыг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гаргаснаар нэр дэвшигч М, Н нар тухайн асуудлаар сонгуулийн маргаан үүсгэж захиргааны хэргийн дагнасан шүүхэд хандаж, улмаар маргааныг захиргааны хэргийн анхан болон давжш заалдах шүүх, цаашлаад Улсын дээд шүүх хяналтын шатны шүүх хуралдаанаараа шийдвэрлэжээ.

Маргаан хянан шийдвэрлэх явцад тойргийн хороо татан буугдсан тул СЕХ тойргийн хорооны эрх залгамжлагчаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна.

Дүгнэлт:

Тухайн маргаантай асуудлыг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрлэхдээ нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байдаг боловч хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шүүхийг “шүүхэд хамааралгүй асуудлаар дүгнэлт өгсөн” гэж үзээд давж заалдах шатны шүүхийн магадлалыг өөрчлөн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөрчил гаргасан гэх нэр дэвшигч Ч, Х нарын УИХ-ын гишүүний бүрэн эрхийг зөвшөөрөх тухай асуудлыг СЕХ-ноос УИХ-д оруулан бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрүүлжээ.

Энэ асуудалд хянанлтын шатны шүүх дүгнэлт өгөхдөө “...Түүнчлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн дагуу шаталсан тогтолцоотой захиргааны байгууллагын эцсийн шат болох сонгуулийн төв байгууллагын шийдвэр эцэслэн гарч, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн нарыг МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 49.3-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган, нийтэд мэдээлсэн, улмаар УИХ-ын гишүүний бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа УИХ-ын гишүүний бүрэн эрхийн талаар шийдвэр гаргах эрхийг захиргааны хэргийн шүүхэд хуулиар олгоогүй байна.” гэсэн тайлбарыг хийжээ. Энэ үндэслэлээр бол тойргийн хороо нь захиргааны хэргийн шүүхэд хариуцагч байх эрхзүйн чадваргүй, тухайн маргаантай асуудлыг тойргийн хороо биш СЕХ шийдвэрлэх ёстой байсан гэсэн дүгнэлт хийгдэж байгаа боловч хяналтын шатны шүүх хэргийг бус нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь мөн л эрхзүйн үр дагаварыг үүсгэж логикгүй байна.

Өөрөөр хэлбэл тухайн маргаантай асуудлыг СЕХ бүрэн эрхийнхээ хүрээнд нэгэнт шийдсэн байхад түүнийг /СЕХ-г/ давж асуудлыг шүүх шийдвэрлэх үндэслэлгүй гэж үзсэн атлаа нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна. Нэгэнт тухайн маргаантай

асуудлыг СЕХ шийдвэрлэх юм бол уг асуудлыг захиргааны хэргийн шүүх хүлээн авч шийдвэрлэх боломжгүй юм. Шүүх хуралдааны явцад шүүх хүлээн авах ёсгүй байсан нь илэрвэл хэрэг үүсгэсэн захирамжийг хүчингүй болгон хэргийг хэрэгсэхгүй болгодог билээ.

Тохиолдол 7.

УИХ-ын 2012 оны сонгуулийн 26 тойргийн дахин санал хураалттай холбогдсон маргаантай асуудал.

УИХ-ын 2012 оны сонгуулийн 26-р тойрог нь гурван мандаттай байх бөгөөд нэр дэвшигчдээс хоёр нь л хуульд заасан 28 хувийн босго давсан тул үлдсэн нэг мандат дээр нь нэр дэвшигч Э, С нарыг дахин санал хураалтад оруулжээ. Харин дахин санал хураалт явуулахдаа санал хурааж дуусах хуульд заасан хугацааг сонгуулийн байгууллагууд буруу тооцоолон хоёр цагийн өмнө дуусгаснаар тухайн маргаантай асуудал үүсчээ.

Тухайн маргаантай асуудлыг СЕХ бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэсэнгүй гэж үзэн иргэн А Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргасан байна. Гэвч Үндсэн хуулийн цэцээс “СЕХ болон тойргийн хорооны сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн асуудлыг Үндсэн хуулийн цэц хянахгүй шүүх шийдвэрлэх боломжтой байна...” гэж үзээд Цэцийн гишүүний тогтоол, Цэцийн магадлал гаргаснаар маргаан цааш үргэлжлээгүй байна.

Дүгнэлт:

Энэхүү маргаантай асуудлыг Үндсэн хуулийн цэц шийдвэрлэхдээ “Үндсэн хуулийн цэц нь зөвхөн Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянаж шийдвэрлэнэ, сонгуулийн төв байгууллагын шийдвэр сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн эсэхийг тогтоогоогүй байхад уг асуудлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх боломжгүй” гэж үзээд харьяаллын бус үндэслэлээр хүлээн авахаас татгалзжээ. Харин цэцийн дээрхи шийдвэрт сонгуулийн төв байгууллагын шийдвэр сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн эсэх асуудлыг “хэн” шийдвэрлэх вэ гэдгийг тодорхойгүй үлдээсэн байгаа нь анхаарал татаж байна.

Гэтэл шүүх /Улсын дээд шүүх/ сонгуулийн төв байгууллагад холбогдсон сонгуулийн холбогдолтой маргааныг Үндсэн хуулийн цэц л шийдвэрлэх ёстой гэсэн байр суурьтай байдаг нь тухайн маргаантай асуудлыг хэн /шүүх үү? цэц үү?/ шийдвэрлэх талаархи Үндсэн хуулийн цэц ба Улсын дээд шүүхийн байр суурь өөр өөр байгааг харуулж байна.

Тохиолдол 8.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2012 оны сонгуулийн үеэр сонгуулийн мөрийн хөтөлбөр

сонгуулийн хууль зөрчсөн эсэх асуудлаар үүссэн маргаан.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын сонгуульд оролцсон Х намын сонгуулийн мөрийн хөтөлбөр хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр уг намыг сонгуульд оролцохоор бүртгүүлсэн шийдвэрийг хүчингүйд тооцуулахаар холбогдох хуулийн заалтыг үндэс болгон А намаас аймгийн сонгуулийн хороонд гомдол гаргажээ. Гэвч аймгийн сонгуулийн хороо тухайн асуудлаар гаргасан гомдлыг хэлэлцэлгүй өнгөрсөн байна. Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд аймгийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдсон маргааныг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхээр заасан тул тухайн маргаантай асуудлаараа гомдол гаргагч А нам захиргааны хэргийн шүүхэд хандаж гомдол гаргажээ. Аймгийн захиргааны хэргийн шүүх уг хэргийн шийдвэрлэхдээ Х намын мөрийн хөтөлбөр хуульд нийцсэн гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол захиргааны хэргийн давж заалдан шатын шүүх үндэслэлийг нь өөрчил тухайн асуудлаар тойргийн хороондоо гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг нэхэмжлэгч А нам хэтрүүлсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ. Маргаан одоо хяналтын шатны шүүхийн шатанд явж байгаа бөгөөд шүүхийн маргаан дуусаагүй ажээ.

Дүгнэлт:

Нэгэнт хуульд сонгуулийн холбогдолтой маргааныг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхээр хуульчилсан тул хэргийн болон шүүхийн харьяаллын асуудлаар ямар нэг гомдол гаралгүйгээр шүүхээр шийдвэрлэгджээ. Харин тухайн маргаан анх нэхэмжлэл гаргаснаас хойш бүтэн нэг жил өнгөрөөд байхад дуусаагүй байгаа нь сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хуулиар нарийн тусгах шаардлагатай байгааг илтгэнэ. Сонгуулийн үр дүнд нь богино хугацаагаар хэмжигддэг тул маргаан хянан шийдвэрлэх хугацаа ч мөн адил бусад төрлийн эрхзүйн маргааныг бодвол онцлог зохицуулалтай байх шаардлагатай.

Тохиолдол 9.

Нийслэлийн Баянгол дүүргийн ИТХ-ын 2012 оны сонгуулийн үеэр гарсан маргаан.

Нийслэлийн Баянгол дүүргийн ИТХ-ын 2012 оны сонгуульд оролцсон Х намаас "хуулийн шаардлага хангаагүй А намын нэр дэвшигч С-ийг дүүргийн сонгуулийн хороо бүртгэсэн нь хууль зөрчсөн." гэж марган нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Тухайн тохиолдолд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан хаагч биш харин түр орлон гүйцэтгэгч байсан тул гурван шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Дүгнэлт:

Орон нутгийн сонгуулийн холбогдолтой маргааныг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхээр хуулиар тодорхой заасан тул хэргийн болон шүүхийн харьяаллын асуудлаар ямар нэг гомдол гаралгүйгээр шүүхээр шийдвэрлэгджээ.

Тохиолдол 10.

Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2012 оны сонгуулийн үеэр үүссэн маргаантай асуудал.

Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2012 оны сонгуулиар аймгийн сонгуульд оролцохоор хүсэлтэй ирүүлсэн М намыг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг аймгийн сонгуулийн хороо гаргаснаар маргаан үүсчээ. Маргааныг хүлээн авсан аймгийн захиргааны хэргийн шүүх хэрэгсэхгүй болгосон боловч давж заалдах болон хяналтын шатны шүүх нэхэмжлэлийг ханган М намыг бүртгэхийг сонгуулийн хороонд даалгаснаар маргаан бүрэн шийдвэрлэгдэж дуусчээ.

Дүгнэлт:

Орон нутгийн сонгуулийн холбогдолтой маргааныг захиргааны хэргийн шүүх хүлээн авч шийдвэрлэхээр хуульд заасан боловч нэгэнт сонгууль дуусаад үр нь гарсны дараа маргаан шийдэгдсэн тохиолдолд хэрхэх вэ гэсэн асуудал тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл тухайн тохиолдолд яах вэ гэсэн харилцааг хууль тогтоогч хуульчлаагүй үлдээсэн нь эрхзүйн тодорхой бус үр дагаварыг буюу нэхэмжлэгч хохироод “үлдэх үү” гэсэн асуудлыг үлдээжээ.

Тохиолдол 11.

Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2012 оны сонгуулийн үеэр үүссэн буюу тохиолдол 10-тай холбогдсон маргаантай асуудал.

Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2012 оны сонгуулиар аймгийн сонгуульд оролцохоор хүсэлтэй ирүүлсэн М намыг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг аймгийн сонгуулийн хороо гаргасан байх ба шүүх уг намыг бүртгэхийг сонгуулийн хороонд даалгасны дагуу үүссэн маргаан.

Нэгэнт шүүхийн шийдвэрийн дагуу аймгийн сонгуульд оролцогчоор М намыг бүртгэхээр болсон боловч сонгууль хэдийнэ дуусаад ИТХ байгуулагдсан байсан тул уг сонгуулийг хүчингүйд тооцуулах, дахин сонгууль явуулах тухай нэхэмжлэлийг М нам дахин шүүхэд гаргасан байна.

Нэхэмжлэлийг хүлээн авсан аймгийн захиргааны хэргийн шүүх хэрэгсэхгүй болгосон боловч мөн л давж заалдах болон хяналтын шатны шүүх нэхэмжлэлийг ханган дахин сонгууль явуулахаар шийдвэрлэжээ.

Дүгнэлт:

Сонгууль дуусаж үр дагавар нь гарсны дараа ч шүүх асуудлыг шийдвэрлэж болдгийг дээрхи тохиолдол нотолж байна. Хамгийн гол нь орон нутгийн хурлын сонгуультай холбогдолтой маргааныг аль шүүх шийдвэрлэхийг хуульд тодорхой заасан байгаа нь тухан маргаан шүүхээр эцэслэн шийдэгдэх нөхцлийг бүрдүүлжээ.

Тохиолдол 12.

Говь-Сүмбэр аймагт нөхөн сонгууль явуулахтай холбогдсон маргаантай асуудал.

Говь-Сүмбэр аймгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшсэн С, О, П, Л нар сонгуулийн сурталчилгааны явцад сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн нь нотлогдсон үндэслэлээр эдгээр нэр дэвшигчдийг аймгийн сонгуулийн хороо нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасч, санал хураалтаар тэдгээр нэр дэвшигчдийн дараа эрэмблэгдсэн нэр дэвшигчдийг сонгогдсон тооцсонтой холбогдуулан М намаас нэхэмжлэл гаргажээ.

Нэхэмжлэлийг анхан болон давж заалдах шатны шүүх хэрэгсэхгүй болгосон ажээ. Харин тухайн тохиолдолд буюу сонгуулийн үргарч нэгэнт С, О, П, Л нарын төлөөлөгчийн бүрэн эрх нэгэнт үүссэн тул тэдгээр төлөөлөгчдийг Хурлын Төлөөлөгчөөс нь эгүүлэн татаж, нөхөн сонгууль явуулах ёстой байсан гэсэн дүгнэлтийг хяналтын шатны шүүх хийн нэхэмжлэлийг хангаж шийдсэн байна.

Дүгнэлт:

Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 34.15-д “Нэр дэвшигч энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасныг зөрчсөн нь нотлох баримтаар тогтоогдсон бол түүнийг нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасна.”, 34.16-д “Санал хураалт болон сонгуулийн дүн гарсны дараа энэ хуулийн 34.15-д заасны дагуу нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хассан бол тухайн нэр дэвшигчийн дараагийн нэр дэвшигчийг сонгогдсонд тооцож, энэ хуульд заасан зохих журмын дагуу тухайн аймаг, сум,

дүүргийн Хурлын төлөөлөгчөөр бүртгэнэ.” гэж заасан байдаг боловч нэгэн сонгууль дуусаад сонгуулийн үр дүнгээр нэр дэвшигч Төлөөлөгчийн бүрэн эрхтэй болсон бол тухайн хуулийн заалт хэрэгжих боломжгүй болж байна.

Дээр дурдсан нөхцөл байдал бүхий л сонгуулийн үед байнга тохиолддог ба зарим этгээд хууль зөрчиж сонгуулийн сурталчилгаа явуулж сонгуульд ялалт байгуулчихаад дараа нь ард түмний сонголтыг өөрлөх гэлээ гэсэн үндэслэлийг гаргаж тавьдаг. Зарим нэр дэвшигч нь хуулийн хүрээнд сонгуулийн сурталчилгаагаа явуулж байхад зарим нь хууль зөрчин сонгуулийн сурталчилгаа явуулж сонгуульд ялалт байгуулдгаас улбаалж хууль зөрчөөгүй нь хожигддог, хууль зөрчсөн нь хождог байдал ужгирч мэдэхээр байна. Үүний үр дагаварт нэр дэвшигч нар болон сонгуульд оролцогч нам, эвслүүд хууль зөрчөөд ч хамаагүй сонгуулийн ялалтад хүрэх замыг сонгож болзошгүй юм. Иймээс энэ маргаантай асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаархи харилцааг хуулиар зайлшгүй тогтоож өгөх шаардлагатай.

ДӨРӨВ.ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны амжилттай хэрэгжиж чадсан туршлага болон хамгийн сайн практикийн давуу болон сул талуудаас сургамж авах, тэдгээрийн онцлог байдалд дүн шинжилгээ хийх замаар тухайн тогтолцооны тодорхой хандлагуудыг танин мэдэж дор дурдсанаар харьцуулсан байдлаар судлан үзлээ.

Сонгуулийн маргаан шийдвэрлэхэд бусад нөхцөл байдал нөлөөлөх нь

Шинээр ардчилалыг бий болгож байгаа улс орнууд сонгуулийн маргааныг шийдвэрлэх сайн механизм, сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэх хамгийн тохиромжтой арга замыг олж, хатуу чанга сонгуулийн хариуцлагын дэглэм, журмыг бий болгож чадсан ч гэсэн сонгуулийн маргаан олноор гарсаар байдаг.

Харин өндөр хөгжилтэй, ардчилал өндөр түвшинд хүрсэн гэж тооцогддог улс орнуудын хувьд сонгуулийн маргаанаас урьдчилан шийдвэрлэх механизмыг хангалттай хэмжээнд тогтоогоогүй, сонгуулийн маргаан болон хариуцлага ногдуулах журам нь энгийн байдаг боловч сонгуулийн холбогдолтой маргаан цөөн гардаг байна. Энэ нь тухайн улсад улс төрийн соёл, болон бусад нөхцөл байдал зөвөөр төлөвшсөнтэй холбоотой байдаг. Жишээ нь Скандинавын орнуудад улс төрийн соёл нь сонгуулийн хуулийн хатуу заалт, журам, заавраас илүүтэйгээр тухайн улсад гардаг сонгуулийн маргааныг зохицуулдаг байна. Мөн зарим улсуудад сонгуулийн дүн маш ойролцоо гарсан ч тухайн маргааныг хялбархнаар шийддэг. Ийм нэг жишээ АНУ-ын Ерөнхийлөгчийн 2000 оны сонгуулиар тохиолдсон юм. Сонгуулийн хямралыг даван туулна гэдэг нь тухайн улсын сонгуулийн маргаанаас урьдчилан сэргийлэх, маргааныг шийдвэрлэх тогтолцоо, бүтцээс гадна улс төрийн тоглогч нарын харилцан зөвшилцөл хийж чадах улс төрийн соёл хир хэмжээнд бүрэлдэн тогтсон гэдгээс мөн

хамаардаг.

Улс орнуудын эрх зүйн тогтолцооны ялгаатай байдлын хамаарал

Улс орнуудын эрх зүйн тогтолцоо нь сонгуулийн маргаан шийдвэрлэх үйл ажиллагаанд нөлөөлдөг. Жишээ нь Ром-Германы буюу иргэний эрх зүйн тогтолцоотой /Испани, Итали, Уругвай гм/ улс орнууд нь эрх зүйн уламжлалтай байдаг бол нийтийн эрх зүйн буюу Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой /Их Британи, АНУ/ улс орнуудад философи, шашин, шударга ёсны уламжлалтай. Эдгээр улсуудад сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд ижил ялгаатай зүйлс байдаг ч, мөн төстэй зүйлс ч байдаг байна. Жишээ нь АНУ болон Итали; Этиоф, Англи, Пакистан, Тайван, Испани, Индонези, Нигер; Палестин, болон Уругвай зэрэг улсууд нь хэдийгээр өөр өөр төрлийн эрх зүйн тогтолцоотой ч гэсэн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны бүтэц болон ажиллагаа нь нилээд ижил байдаг. Үүнээс дүгнэхэд сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцоо нь эрх зүйн тогтолцооны онцлогоос хамаарахгүйгээр ижил болон ялгаатай шинжүүдтэй.

Сонгуулийн маргааныг урьдчилан шийдвэрлэх

Олон улсын хүний эрхийн хэд хэдэн гэрээ, конвенцид хүний зөрчигдсөн эрхийг хараат бус шүүхээс өмнө үр дүнтэйгээр хамгаалах хамгаалалт байх шаардлагатайг тогтоосон.

ОУ-ын Парламентын Хорооноос 1994 онд баталсан Чөлөөт, шударга сонгуулийн шалгуурын тухай тунхаглал

Хэсэг 4.9

‘Тунхаглалд нэгдэн орсон талууд нь хүний эрхийн зөрчил, сонгуулийн ажиллагаатай холбоотой гомдлыг нэн даруй шүүх, сонгуулийн хороо зэрэг хараат бус, төвийг сахисан эрх бүхий байгууллага үр дүнтэйгээр шийдвэрлэнэ.’

Шүүхийн шатанд маргааныг шийдвэрлүүлэхээс өмнө тухайн улсын хуульд заасан гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага нь тухайн сонгуулийн хууль бус үйлдлийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэмт хэрэг гэж үзвэл хорих ял болон торгуулийн ял оногдуулж болно. Харин зарим улс орны хувьд сонгуулийн эрх бүхий байгууллага нь тухайн зөрчил маргааныг хэлэлцэн шийдэж, үр дүнг хүчингүй болгох, өөрчлөх тухай урьдчилсан шийдвэрийг гаргаж болдог бөгөөд энэ шийдвэр нь шүүхээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог.

Сонгуулийг зохион байгуулдаг этгээд нь мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж болдог. Зарим орны сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгууль зохион байгуулдаг байгууллага, албан тушаалтан нь сонгуулийн маргааныг авч хэлэлцэх,

байцаалт явуулах зэрэг захиргааны хариуцлагын хуульд заасан процедурыг явуулсаны дараагаар тухайн улс төрийн нам эсхүл, нэр дэвшигч нь захиргааны зөрчил (гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй захиргааны зөрчил) гаргасан тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэх, жишээ нь торгууль ногдуулж болох бөгөөд уг шийдвэрийг голдуу шүүхийн өмнөх шатанд гомдол гаргах боломжтой байдаг. Харин зарим орны ялангуяа нийтийн эрх зүйн системтэй орнуудын хувьд сонгуулийн зөрчилтэй холбоотой захиргааны хариуцлагыг иргэн, захиргааны болон эрүүгийн шүүхүүд нь ногдуулдаг.

Олон улсын баримт бичигт сонгуулийн маргааныг шийдвэрлэх зарчмыг тодорхойлсон талаар

Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд сонгуулийн эрх түүнийг тодорхойлох олон зарчмуудыг дэлгэрүүлэн тодорхойлж, ялангуяа сонгуулийн эрхийг хамгаалж, сэргээн тогтоодог сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны эрх, зарчмуудыг оруулсан. Эдгээр зарчмуудад шүүхийн өмнөх шатанд сонгуулийн эрхийг үр дүнтэйгээр шударгаар хамгаалах, шүүхийн үйл ажиллагаа хууль ёсны дагуу болон нийтэд ил тодоор явагдах зэрэг зарчмууд бөгөөд эдгээр нь сонгуулийн эрхийн хамгаалалт болж бүхий л талаар тэгш байдлын баталгаа болдог.

Авери Давис Робертс

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын конвенц болон бүс нутгийн баримт бичгүүдэд Африкын хүний эрхийн тунхаг, Америкын хүний эрхийн конвенц болон Хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах Европын конвенц зэрэг нь олон улсын эрх зүйд үндэслэдэг сонгуулийн маргааныг шийдвэрлэх механизмын зарчмуудыг суурь болгон оруулсан. Цаашлаад, НҮБ-ын Хүний эрхийн хорооны гаргасан 31, 32 дугаар ерөнхий тайлбар, Венецийн комиссын Сонгуулийн шилдэг туршлага, дүрмийн журам болон бусад эх сурвалжууд нь эдгээр зарчмуудыг илүү тодорхой ойлгоход туслана. Хэдийгээр эдгээр баримт бичиг сонгуулийн маргааныг шийдвэрлэх механизмтай холбоотой асуудлыг шууд илэрхийлээгүй харин сонгуулийн эрхийг үр дүнтэйгээр хамгаалах хамгаалалтын арга хэрэгсэл, шүүхийн нээлттэй, шударга байдал зэрэг ерөнхий эрхүүдийг илүү өргөн хүрээнд харуулсан нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх процессын ойлголтыг багтаасан.

Эдгээрт сонгуулийн бүхий л үйл ажиллагаа нь хуулийг дээдлэх зарчмыг харгалзан үзэж, төр нь сонгуулийн бүхий л үе шатанд хүний эрхийг баталгаажуулж, хангах арга хэмжээг хэрэгжүүлсэн байх шаардлагатай гэж үзсэн ба сонгуулийн маргааныг шийдвэрлэх хамгийн чухал ач холбогдолтой асуудал нь үр дүнтэй хамгаалалтын эрхийг хэрэгжүүлэх ажиллагаа буюу хуулийн өмнө шударга, нээлттэй болон тэгш байдлаар маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа гэдгийг тодруулжээ.

Улс төрийн үйл хэрэгт хүн бүр оролцох эрхийг хамааруулан, хүний эрхийн баримт бичгүүдэд тусгалаа олсон сонгуулийн эрхээ үр дүнтэйгээр хамгаалуулах. Энэхүү эрх зүйн хамгаалалтыг хуулиар баталгаажуулсан тохиолдолд заавал хэрэгжих ёстой гэж дүгнэжээ. Сонгуулийн эрхийг хамгаалах эрх зүйн үр дүнтэй хамгаалалтууд нь зөвхөн шүүхээр хамгаалагдахаар хязгаарлагдахгүй харин уг хамгаалалтын механизмын тохиромжтой байдлаар зөрчил, маргааныг бүрэн шийдвэрлэж, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох явдлыг хангасан байх ёстой заажээ. Улс орнууд иргэний эрхийг зөрчсөн тохиолдлыг мөрдөн шалгаж, үүнд хамаарах бүхий л захиргааны механизмуудыг бүрдүүлэх шаардлагатай. Тухайлбал, хүний эрхийн комисс зэрэг байгууллагыг байгуулж, уг байгууллага нь эдгээр үүргийг биелүүлэх боломжийг хангаж өгөхийг тодруулсан. Түүнчлэн төр нь гуравдагч этгээд болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хүний эрхийн зөрчлийг арилгах зохицуулалтыг бий болгох үүрэгтэй гэсэн.

Үүний зэрэгцээ, хүн бүр өөрийн эрхийн талаарх ойлголтыг шударгаар болон олон нийтэд нээлттэй хэлбэрээр мэдэж авах эрхтэй. Хуульд нийцсэн хүний эрхийн талаарх ойлголт хүрээнд хүн бүр хараат бус, бие даасан шүүхийн аль нэг шатанд хандан өөрийн эрхээ хамгаалуулах баталгаа, боломжоор хангагдсан байх шаардлагатай. Шүүх нь гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас хараат бус байж, хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ шүүхийн хараат бус байдлыг хангах ёстой. Хараат бус байхын тулд шүүгчийн шийдвэр нь хэргийн талуудын аль нэгэнд нь боломж олгох эсхүл, нөгөө талынх нь эрх ашгийг

хохироох байдлаар хэргийг шийдвэрлэхээс өмнө тодорхой ойлголттой болсон байх болон нэг талын эрх ашгийг зүй бусаар хамгаалах ёсгүй. Хамгийн чухал нь тухайн шүүх ажиллагаа хараат бус болж байгааг олон нийт ажиглах боломжийг бүрдүүлэх ёстой. Шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах шаардлагатай. Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй байдал нь ил тод байдлыг ханган, нийтийн эрх ашгийг хамгаална гэж заажээ.

Хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй бөгөөд аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр хуулийн хамгаалалтыг тэгш байдлаар хүртэх эрхтэй. Цаашлаад, хүн бүр шалтгаангүй хязгаарлалт, ялгаварлалгүйгээр шүүхэд хандах эрхээ эдэлж, өөрийн эрхээ хамгаалахад тэгш эрхтэй оролцох талаар дурджээ.

Түүнчлэн хэн бүхэн мэдээлэл хайх, авах эрхтэй бөгөөд үүний хүрээнд тухайн гомдлыг хэрхэн авч үзэж буй, ямар үр дүн гарч буй, ямар нотлох баримт олдоод буй, хууль зүйн ямар үндэслэлийг тогтоосон зэрэг мэдээллийг авах эрхтэй. Тухайн шүүхийн үйл ажиллагаа нь олон нийтэд хаалттай байсан ч гэсэн дээрх асуудлуудаар мэдээлэл авах бүрэн эрхтэй гэж оруулсан.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын төрөл

Олон улсын хэмжээнд сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудыг ерөнхийд нь ангилбал:

- Захиргааны байгууллага: сонгууль зохион байгуулах эрх бүхий сонгуулийн ерөнхий, тойргийн, хэсгийн байгууллага, комисс хамаарна;
- Шүүхийн байгууллага: байнгын ажиллагаатай ердийн шүүх, салбар шүүх, Үндсэн хуулийн шүүх, эрх мэдлээс тусдаа бүтэц бүхий дагнасан сонгуулийн шүүх, захиргааны хэргийн шүүх хамаарна;
- Хууль тогтоох байгууллага: хууль тогтоох байгууллага бүхэлдээ хамаарах бөгөөд жишээ нь уг байгууллагын бүрэлдэхүүнд хамаарах байнгын хороо мөн орно;
- Олон улсын байгууллага: олон улсын болон бүс нутгийн шүүхийг ойлгох бөгөөд Европын хүний эрхийн шүүх, Америкийн хүний эрхийн шүүх зэрэг орж болох бөгөөд эдгээрийн гаргах шийдвэрийг тухайн шүүхийн харъяалалд хамаарах улс орнууд дагаж мөрдөх үүрэгтэй байдаг.
- Түр хугацааны байгууллага: түр хугацааны үйл ажиллагаатай, зөвхөн тухайн маргааныг шийдвэрлэх зорилгоор байгуулагддаг байгууллагууд хамаарна.

Зарим сонгуулийн маргааныг хууль тогтоох байгууллага эцэслэн шийдвэрлэх талаар

Анхны төлөөллийн ардчиллын дэглэм бий болж байхад сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгуулийн үр дүнгийн талаарх эцсийн шийдвэрийг хууль тогтоох байгууллага баталгаажуулдаг байсан. 19 дүгээр зууны 3 дахь үеийн сүүлээр

сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд шүүхийн байгууллагаар маргааныг шийдвэрлүүлэх процедур Англид бий болсон бөгөөд хууль тогтоох байгууллагын сонгуультай холбоотой шийдвэрлэж байсан маргааныг шүүх хянан шийдвэрлэх болжээ. Хэдийгээр зарим улс орнуудад одоог хүртэл хууль тогтоох байгууллага нь сонгуультай холбоотой зарим эцсийн шийдвэрийг гаргадаг эрхтэй хэвээр байгаа ч гэсэн ихэнх улсууд энэхүү эрхийг аажмаар шүүхийн байгууллагад шилжүүлэх болжээ. Ерөнхийд нь авч үзвэл, хууль тогтоох байгууллага сонгуулийн маргаанд оролцдог байсан байдлаас хууль тогтоох байгууллага, захиргааны байгууллага болон шүүхийн байгууллагууд холимог байдлаар энэхүү эрхийг хэрэгжүүлэх болсон.

Зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгууль хүчинтэй эсэх талаар эцсийн шийдвэр гаргах болон мөн сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхийг хууль тогтоох байгууллагад, үүний аль нэг хороонд эсхүл улс төрийн эвсэлд олгосон байдаг. Францын уламжлалаар үүнийг “эрх мэдлийг баталгаажуулах” хэмээн нэрлэдэг бол АНУ-д уламжлалын дагуу “сонгуулийг шалгах болон гэрчлэх” гэж нэрлэдэг байна.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд улс төрийн эвсэлийг оролцуулах явдал нь анх Францад үүсэн бий болж, 18 дугаар зуунаас 1958 оны сонгуулийг хүртэл үргэлжилжээ. АНУ-д үүнийг 1787 оны Үндсэн хуулиар бий болгосон. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд хууль тогтоох байгууллага эсвэл улс төрийн эвсэл оролцох нь 19 дүгээр зуунаас эхлэн 20 дугаар зууныг дамжин үргэлжилсэн ардчилсан ёсны нэг түгээмэл хэлбэр болсон.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог хууль тогтоох байгууллагад хариуцуулах болсон түүх нь эрх мэдлийг хуваарилах зарчим дээр суурилсан бөгөөд засаглал бүр харилцан хамааралгүй, бие даасан шийдвэр гаргах боломжийг хангах зорилгыг хэрэгжүүлэх үүднээс ийнхүү сонгуулийн маргааныг хууль тогтоох байгууллага хариуцах нь зүйтэй гэж үздэг. Тухайлбал, хууль тогтоох засаглал нь шүүх засаглалаас хараат бус байх шаардлагын дагуу ийнхүү хууль тогтоох байгууллагын бие даасан байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Энэ нь шүүх засаглалыг улс төрийн аливаа тэмцэл, маргаантай хутгалдуулах, шүүх аливаа хэрэг, маргааныг мэргэжлийн үүднээс хууль ёсны дагуу шийдвэрлэх үндсэн чиг үүрэгт нь хохирол учруулахаас зайлсхийхэд чиглэгддэг байна. Цаашлаад, Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хүрээнд хууль тогтоох байгууллага голлох үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн үзэл санааг баримтлагчид шүүхийн байгууллагын шийдвэр нь хууль тогтоох байгууллагын шийдвэрээс давуу хүчин чадалтай байх нь ардчилсан бус шинжийг агуулна гэж үздэг байн

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо: Хууль тогтоох байгууллага эрхээ хэтрүүлсэн үйлдэл 1958 оноос өмнө Францад гарсан талаар

“Францад 1958 оноос сонгуулийн эрхийг баталгаажуулах эрхийг улс төрийн эвсэлд байсныг өөрчилж Үндсэн хуулийн консулд олгожээ. Улс төрийн намуудын эвсэлд энэхүү эрхийг олгож байсан нь урт удаан хугацааны түүхтэй байжээ. Эзэнт гүрний үед төрийн зөвлөлөөс энэхүү эрхийг болиулсан ч гэсэн, тухайн системийг 1814–15 онуудад дахин сэргээн Парламентын танхимд олгож Гуравдугаар Бүгд Найрамдах Улсын хувьд Үндсэн хуулиар статусыг нь баталгаажуулсан түүхтэй. Гэсэн ч 1940-өөд оны үеэс тухайн хууль тогтоох байгууллагаас энэхүү эрхээ зүй бусаар хэтрүүлэн ашиглах болсон байна. Үүний улмаас Дөрөвдүгээр Бүгд Найрамдах Улсын 1946 оны 10 дугаар сарын 27-ны Үндсэн хуулийн 8 дугаар зүйл дээр Парламентын хоёр танхим нэг бүр нь өөрийн сонгогдсон гишүүдийн эрхийг баталгаажуулах болохыг зааж өгсөн байдаг. Ингэснээр тухайн хуучин системийг нураасан байна. 1946-1958 оны үед эрх барьж байсан улс төрийн намууд хуулийг үл хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулж, тэдний гаргасан шийдвэр нь зөрчилтэй байснаас үүдэн хуулийн хэрэгжилтэд ихээхэн хүндрэл учруулж байжээ. 1946 онд тэд Үндэсний Ассемблейд сонгогдсон этгээдийн эрхийг хүчингүй болгож, тухайн хэрэглэж байсан систем нь 1946 болон 1951 онуудад гадаад нутаг дэвсгэрт болсон сонгуулийн үр дүнд сэргээр нөлөөлж, олонхи болсон нам нь 1951 болон 1958 онуудад өөрсдийн суудлаа сэргээх боломжийг олгож байжээ. Ийнхүү сонгуулийн үр дүнг баталгаажуулахтай холбоотой асуудлаар өргөн хүрээний хэлэлцүүлэг явагдаж Үндэсний Ассемблейд итгэх итгэлийг сулруулж байжээ.

Зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд хууль тогтоох байгууллага болон улс төрийн эвслээс эрхээ хэтрүүлэх явдлыг хязгаарлах зорилгоор сонгуулийн аливаа маргааныг шийдвэрлэх эрхийг нь шүүхэд өгч, харин сонгууль хүчинтэй байдал болон сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөх талаарх эцсийн шийдвэр гаргах эрхийг хууль тогтоох байгууллагад үлдээсэн байдаг.

Зөвхөн хууль тогтоох байгууллага, эсхүл улс төрийн намуудад сонгуулийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой шийдвэр гаргах онцгой эрхийг олгосон сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо өнөөдрийн практикт байдаггүй. Хууль тогтоох байгууллагын болон Ерөнхийлөгчийн сонгуульд энэ тогтолцоог ашигладаг улсууд нь ихэнхдээ холимог байдлаар ашигладаг. Үүнд:

(а)сонгуулийн үр дүнг бус сонгуулийн үйл ажиллагаа болон шийдвэрийг шүүх урьдчилан шийдвэрлэдэг (Аргентин болон Бельги улсууд), эсхүл сонгуулийн шийдвэр болон сонгуулийн үр дүнг шүүх шийдвэрлэх (АНУ, Итали, Латви, Литва, харин Дани, Нидерланд, Норвег, Швейцар үүнд орохгүй);

(б)сонгуулийн үр дүнгийн талаарх хууль тогтоох байгууллагын шийдвэрийг шүүх хянан үзэх (Германд Үндсэн хуулийн шүүх нь үүнийг хэрэгжүүлдэг). Үүнээс дүгнэхэд хууль тогтоох-шүүх байгууллагын, хууль тогтоох-захиргааны байгууллагын,

эсхүл шүүх-хууль тогтоох байгууллагын зэрэг сонгуулийн маргаан шийдвэрлэх холимог тогтолцоо байдаг.

АНУ нь хууль тогтоох-шүүх байгууллагын сонгуулийн маргаан шийдвэрлэх холимог тогтолцоотой. Муж улс бүрийн эрх бүхий байгууллагаас гаргасан журмын дагуу зохион байгуулагдсан холбооны сонгуультай холбоотой маргааныг ерөнхийдөө эхлээд муж улсын ердийн шүүх шийдвэрлэж (муж улсын шүүхийн шийдвэрийг Дээд шүүх нь хянан үзэж түүнийг Дээд шүүхээс албан ёсоор мэдэгддэг), дараагийн шатанд Төлөөлөгчдийн танхим эсвэл Сенат хэлэлцэн эцсийн шийдвэрийг гаргадаг. Түүнчлэн АНУ-ын Конгресс нь Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу Ерөнхийлөгчийн сонгуулийн саналыг тоолдог. Төлөөлөгчдийн танхим болон Сенатын олонхийн санал хураалтыг 1887 оны Сонгуулийн хуулийн дагуу явуулан, тухайн муж улсын гаргасан Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнтэй холбоотой шийдвэрийг өөрчилсөн байдаг. Орон нутгийн маргааныг муж улсын шүүхийн шийдвэр гарсны дараа түүнийг шилжүүлдэг.

Үүний нэгэн адил Латви улсын Үндсэн хуулийн 105, 107 дугаар зүйлийн дагуу Үндсэн хуулийн шүүх нь Ерөнхийлөгчийн сонгууль болон хууль тогтоох байгууллага болох Сеймасын сонгууль зөрчилтэй холбоотой шийдвэрийг гаргаж, Сеймас нь Үндсэн хуулийн шүүхийн гаргасан шийдвэрт үндэслэн эцсийн шийдвэрийг гаргадаг. Латви улсын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиар сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх эрхтэй Захиргааны хэргийн шүүхийг байгуулсан байдаг. Үндсэн хуулийн дагуу Сейма нь өөрийн гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх дүгнэлт гаргадаг.

Швейцарын холбооны улсад Үндэсний зөвлөл болон Муж улсуудын зөвлөл нь өөр өөрийн гишүүдийг сонгох сонгуулийн талаар эцсийн шийдвэрийг гаргадаг. Үүнээс өмнө санал тоолох болон сонгуулийн үр дүнг баталгаажуулахтай холбоотой маргааныг мужууд болох кантонуудын улс төрийн эрх бүхий байгууллага дээр шийдвэрлэдэг.

Аргентин болон Швейцар улсуудаас гадна Бельги, Исланд, Голланд, Норвег улсуудад, мөн зарим социализмаас ардчилсан тогтолцоонд шилжих шилжилтийн үе дээрээ буй Төв болон Зүүн Европын орнуудад хууль тогтоох байгууллага нь өөрийн эрхийг хүлээн зөвшөөрөх тодорхой хугацааг тогтоодог. Хэрэв энэ хугацаанд сонгуулийн бүрэн эрхээ хүлээн зөвшөөрөх талаар ямар нэг шийдвэр гаргаж чадаагүй бол шүүх үүнийг шийдвэрлэдэг байна.

Аргентин улсын сонгуулийн маргаан шийдвэрлэх хууль тогтоох-захиргааны гэсэн холимог тогтолцоотой. Хууль тогтоох байгууллагын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнтэй холбоотой аливаа маргааныг үүнд хамруулан авч үздэг байна. Эдгээрээс бусад сонгуулийн үйл ажиллагаа болон шийдвэртэй холбоотой маргааныг Үндэсний сонгуулийн танхим шийдвэрлэх бөгөөд уг танхим нь шүүх эрх мэдлийн салбартаа харьяалагддаг. Сонгуулийн байгууллага буюу өөрийн бүрэлдэхүүнд шүүгч нарыг багтаасан захиргааны шинжтэй хэмээн тооцогдох тус хороо нь сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэсний дараагаар сонгууль хүчинтэй эсэх талаарх эцсийн шийдвэрийг хууль тогтоох байгууллага эсхүл улс төрийн эвсэл гаргадаг ажээ. Үндсэн хуулийн 1994 оны шинэтгэлийн дагуу Үндэсний Конгресс, түүний хоёр танхим нь Ерөнхийлөгчийн болон Дэд Ерөнхийлөгчийн шууд сонгуультай холбоотой зөрчил, маргааныг шийддэг байжээ. Үндэсний конгрессын хоёр танхимын сонгуулийн хувьд Депутатуудын танхим болон Сенат нь өөрийн гишүүдийн эрхийг хүчинтэй эсэхийг баталгаажуулдаг ба харин үүнийг шүүхийн байгууллага хянан үзэх шаардлагатай гэсэн маргаан гарсаар байдаг. Энэ нь Паттигын хэргээс шалтгаалсан ажээ. (Хэрэг no. 4207/06 CNE, 2006 оны 9 дүгээр сарын 14).

Зарим сонгуулийн ажиллагаатай холбоотой маргаан (жишээ нь улс төрийн намуудын сонгуулийн санхүүжилт хаанаас гарч буй, хэрхэн зарцуулж буйг шалгах, сонгуулийн хүчинтэй эсэхийг тогтоох, нэр дэвшигчийг сонгогдсон эсэхийг зарлах эрхгүй байгууллага зарласан зэрэг маргаан)-ыг шүүхээс өөр байгууллага эцэслэн шийдвэрлэдэг практиктай улс орон байдаг. Жишээ нь Итали улсад сонгууль хүчинтэй эсэх дээрх эцсийн шийдвэрийг гаргах, хууль тогтоох байгууллага дахь суудлыг хуваарилах эрхийг Депутатуудын танхим эсвэл Сенат эдэлдэг бол үүнээс өмнө гарсан сонгуультай холбоотой зөрчлийг Дээд шүүхийн харьяа байгууллага болох Үндэсний төв сонгуулийн алба эцэслэн шийддэг. Гэхдээ улс төрийн намуудын санхүүжилттэй холбоотой асуудлуудыг аудитын шүүх хариуцан шийддэг ажээ. АНУ-ын хувьд хууль тогтоох байгууллагын сонгуулийн талаарх эцсийн шийдвэрийг гаргах эрх бүхий байгууллага нь Төлөөлөгчдийн танхим эсвэл Сенат нь өөрийн гишүүнчлэлийн асуудлыг хариуцдаг, харин Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд Конгресс бол мужуудын хэмжээнд гарсан шийдвэрийг өөрчлөхөд Төлөөлөгчдийн танхим, Сенат хоёр нь зэрэг санал хураалт явуулан шийддэг байна. Хэдийгээр хуульд заасан ч энэхүү үйл явц Ерөнхийлөгчийн 1876 оны сонгуулиас хойш огт тохиолдоогүй юм. Хамгийн түгээмэл тохиолдсон сонгуулийн асуудлуудыг үндсэндээ Дээд шүүх нь шийддэг байна. Үндэсний хэмжээний хууль тогтоох байгууллагын сонгуулийн хувьд маш цөөн асуудлыг л Төлөөлөгчдийн танхим болон Сенатаар шийдүүлж байжээ.

Сонгуулийн маргааныг шүүх хянан шийдвэрлэх талаар

Сонгуулийн маргааныг шүүх шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн маргааны талаар эцсийн үр дүн эсхүл, эцсийн шийдвэр гаргаж байгаа гэдгээс шалтгаалж дор

дурдсанаар ангилдаг байна. Үүнд:

- Ердийн шүүх;
- Үндсэн хуулийн шүүх эсхүл консул;
- Захиргааны хэргийн дагнасан шүүх;
- Сонгуулийн тусгай шүүх.

Сонгуулийн маргааныг ердийн шүүх шийдвэрлэдэг талаар

Сонгуулийн маргаан, түүний үр дүнгийн талаарх эцсийн шийдвэрийг сонгуулийн асуудлаар тусгайлан мэргэшээгүй ердийн шүүхийн шүүгч эсхүл шүүх шийдвэрлэдэг жишиг юм. Ихэнх тохиолдолд сонгуулийн маргааны талаарх эцсийн шийдвэр гаргах эрхийг тухайн улсын Дээд шүүхэд олгодог бөгөөд маргааныг шууд Дээд шүүх хянан шийдвэрлэх, эсхүл доод шатны шүүхийн шийдвэрийг давж заалдсан тохиолдолд энэхүү эрхийг Дээд шүүх хэрэгжүүлдэг. Ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь 1868 онд (1983 онд шинэтгэл хийсэн) анх Их Британид бий болсон ба Нийтийн танхим дахь олонхийг гаргаж буй хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох зорилгоор анх уг шийвэрийг гарсан ажээ. Тухайн үед гарсан эрх зүйн баримт бичгийн дагуу сонгуультай холбоотой маргааныг шийдэх эрхийг Хатан хааны дээд шүүхийн (ротацын журмаар шүүгч нар нь солигдож байдаг) хоёр шүүгчид хариуцуулжээ. Мөн тухайн хоёр шүүгчийн гаргах шийдвэрийг Нийтийн танхим хэлэлцэн баталж Парламентын бүрэн эрхийг хангаж байхаар зааж өгсөн байна. Тухайн сонгогдсон шүүгчид нь Танхимын Спикерт ажлаа тайлагнаж, улмаар нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж байжээ. Хэрэв шүүгч нар тухайн гишүүний суудалд өөр нэр дэвшигч томилогдох ёстой хэмээн үзсэн тохиолдолд Танхим нь тэдний шийдвэрийг даган биелүүлэх шат дараалсан арга хэмжээг авдаг байв. Тухайн үед хэдийгээр сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг шүүхийн салбарт шилжүүлсэн ч гэсэн Нийтийн танхим нь өөрийн гишүүнчлэлийн асуудлыг хариуцан шийдэж байжээ.

Австрали, Пакистан болон Ямайка гэх мэт Англи хэлтэй Карибын орнууд зэрэг хамтын нөхөрлөлийн орнуудад дээрхээс бага зэрэг ялгаатай өөр нэгэн системийг авч хэрэгжүүлжээ. Энэхүү системийн хүрээнд эцсийн шийдвэрийг сонгуулийн шүүх гаргах бөгөөд энэ шүүхийн шүүгч нар нь эхний хэлэлцүүлэг бүрийн дараагаар ротацын журмаар өөрчлөгддөг байна. Үүнтэй адилаар системийг Канад, Энэтхэг улсад хэрэгжүүлдэг ба үүний хүрээнд сонгуулийн маргааныг шүүх шийдвэрлэдэг байна. Түүнчлэн Энэтхэг улсад Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр гарсан маргааныг Дээд шүүх шууд гардан шийддэг ажээ. Австрали, Канад болон Энэтхэг улсуудад хараат бус, бие даасан Сонгуулийн байгууллага нь сонгуулийн маргаан шийдэх системд гол үүргийг гүйцэтгэдэг.

Төв болон Зүүн Европын зарим орнууд дээр дурдсантай адил сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоотой. Жишээ нь Босни Герцеговина, Эстони, Унгар,

Польш, Орос болон Серби улсуудад сонгуулийн үр дүнтэй холбоотой гарсан маргааны эцсийн шийдвэрийг Дээд шүүх нь шийдвэрлэдэг ба сонгуулийн өмнөх шатанд гарсан зөрчлүүдийг бие даасан сонгуулийн байгууллага эцэслэн шийддэг байна. Унгар, Орос зэрэг улсуудад сонгуулийн байгууллагын гаргасан зарим шийдвэрийг доод шатны шүүх нь шийдвэрлэдэг байна.

Этиоф, Кени, Лесото, Тайван, Уганда улсуудад хууль тогтоох байгууллагын сонгуулийн маргааны талаарх эцсийн шийдвэрийг шүүхийн байгууллага гаргадаг. Анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдсан тохиолдолд Дээд шүүх нь тухайн маргааныг эцэслэн шийдвэрлэдэг байна. Тайван, Уганда улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой маргааныг Дээд шүүх нь шийдвэрлэдэг. Тайванд Ерөнхийлөгчөөс бусад сонгуультай холбоотой бүх асуудлыг захиргааны хэргийн шүүх нь шийдвэрлэдэг уг шүүхийн шийдвэр нь эцсийн байдаг ажээ.

Япон, Киргизстан, Өмнөд Солонгос, Узбекистан, Вануату улсуудын хувьд хууль тогтоох байгууллагын сонгуультай холбоотой маргааныг Дээд шүүх нь шийддэг ба Япон, Киргизстан улсуудын Дээд шүүх нь тухайн маргааныг зөвхөн давж заалдах журмаар шийдвэрлэдэг бол Өмнөд Солонгос, Узбекистан, Вануату улсуудын Дээд шүүх нь сонгуулийн маргааныг анх шатны журмаар шийдвэрлэдэг байна.

Дэлхий нийтээр хамгийн түгээмэл хэрэглэж буй сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо сонгуулийн үр дүнтэй холбоотой эцсийн шийдвэрийг ердийн шүүхээр шийдвэрлүүдэг тогтолцоо юм. Ийм төрлийн сонгуулийн тогтолцоог сонгон авсан аливаа улс орон шүүх эрх мэдлийн салбарын хараат бус, бие даасан байдлыг юуны түрүүнд хангах шаардлагатай байдаг. Энэ нь ардчилалыг шинээр бий болгож байгаа болон бэхжүүлж байгаа аливаа улс орнуудад чухал ач холбогдолтой гэж үздэг. Ийм тогтолцооны нэг сул тал нь шүүхийн салбарт итгэх итгэл, найдвар султай, тухайн салбар нь хараат бус байдлаа алдсан түүнчлэн гүйцэтгэх болон улс төрийн намын хяналтанд байдаг бол сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд ноцтой хор хохирол учруулах боломжтой байдаг.

Сонгуулийн маргааныг Үндсэн хуулийн шүүх хянан шийдвэрлэх талаар

Дэлхийн 1 дүгээр дайнаас хойш (1914-1918) хэрэгжиж эхэлсэн Европын орнуудын Үндсэн хууль болон Австрийн 1920 оны загвар Үндсэн хууль нь сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг Үндсэн хуулийн шүүхэд олгосон бөгөөд зарим улсуудад энэхүү Үндсэн хуулийн шүүхийг шүүх эрх мэдлийн салбарын нэг хэсэг хэмээн тооцдог байсан бол зарим улсууд шүүхийн салбарт хамааруулдаггүй байна. Австри улсад Парламентын сонгуулийн дүнг баталгаажуулах эрхийг 1920 оноос хойш Холбооны үндсэн хуулийн шүүхэд (Verfassungsgerichtshof) олгосон бөгөөд улмаар цаашид амжилттай шинэчлэл хийж ардчилсан зарчмуудыг тусгаж өгчээ. Энэхүү шүүхээс

үндэсний Конгресс болон орон нутгийн парламентын сонгуулийг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар цуцлах, дахин явуулах тухай шийдвэр гаргах эрхтэй байдаг.

Герман улс нь мөн ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоотой орнуудад хамаардаг. Сонгуулийн дүнг баталгаажуулах эрхийг Бундестагт (Парламентын доод танхим хэмээн тооцогддог) олгосон байдаг. Түүний гаргах шийдвэрийг Холбооны Улсын хэмжээний Үндсэн хуулийн шүүхэд хандан давж заалдаж болдог. Энэ байдлаас харахад шүүхийн-хууль тогтоох байгууллагын аль аль сонгуультай холбоотой асуудлыг шийдвэрлэж болдог хосолмол тогтолцоотой байгаа боловч Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүх нь эцсийн шийдвэр гаргаж байгаа учраас уг тогтолцоог шүүхийн систем давамгайлсан гэж хэлж болно.

Герман улс дахь шүүхийн-хууль тогтоох байгууллагын хосолмол тогтолцоо: гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын сонгуулийн хяналт

Ралф Линднер

Герман улсын Холбооны сонгуулийн үйл ажиллагааг Холбооны сонгуулийн хянагч (Bundeswahlleiter), 16 lander-ийн сонгуулийн хянагч, (Landeswahlleiter) болон бусад хянагч (Kreiswahlleiter) нарын хамтаар хянаж байдаг. Холбооны сонгуулийн хянагч нь уламжлалын дагуу Холбооны статистикын албаны дарга байх ба түүнийг Холбооны дотоод хэргийн яамнаас томилдог бол бусад хянагч нарыг мужуудын захиргаанаас томилдог. Хянагч нар нь өөрийн нутаг дэвсгэрийн сонгуулийн комиссын даргаар ажилладаг.

Холбооны сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог Парламентын хороо (Wahlprüfungsausschuss) эрхлэн явуулж, тус хороонд Бундестагын 9 гишүүн болон 9 депутат ажилладаг байна. Тухайн хороонд хандан шийдвэрлүүлээгүй ямар нэгэн зөрчлийн хувьд үүнийг зөвлөлдөх хороонд ханддаг байна. Тус хорооны гишүүдийг Парламент дангаараа сонгон, тус хороо нь гарсан бүх гомдлыг авч хэлэлцдэг. Тухайн хороонд Парламент дахь намуудын төлөөлөл багтдаг ажээ. Тус хорооны гаргасан бүх шийдвэрийг Үндсэн хуулийн шүүхэд хандан давж заалдаж болох ч иргэний зүгээс давж заалдах тохиолдолд дор хаяад тухайн нэхэмжлэлийг дэмжсэн 100 гарын үсэг цуглуулсан байх шаардлагатай.

Давж заалдах шатны эцсийн шийдвэр гаргадаг шүүх нь Үндсэн хуулийн шүүх хэдий ч сонгуулийн үйл явцыг гүйцэтгэх засаглал (Сонгуулийн байгууллагаар дамжуулан), Парламент (сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоогоор дамжуулан) хянаж байдаг. Маргаан шийдвэрлэх ажиллагаа нь хоёр жил хүртэл хугацаанд үргэлжилж болох ба (Хороон дээр нэг жил, Үндсэн хуулийн шүүх дээр нэг жил), зарим тохиолдолд илүү удаан үргэлжилж ч болно. Гомдлыг зөвхөн сонгууль дуусаж, парламент бүрдсэний дараа л гаргаж болох тул сонгуулийн өмнөх үе шатанд гарсан аливаа маргааныг сонгуулийн дараа шийддэг. Хэдийгээр энэхүү тогтолцоог өөрчлөх санал гарсаар байгаа боловч ийм төрлийн өөрчлөлт, шинэтгэл хийгдэх эсэх нь тодорхойгүй байна.

Францын Үндсэн хуулийн зөвлөл нь мөн л ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны нэг жишээ юм. Энэ байгууллага 1958 оноос хойш нь Ерөнхийлөгчийн сонгууль болон бүх нийтийн санал асуулгын дүнг баталгаажуулах эрхийг эдэлж ирсэн бөгөөд санал хураалтын дүнг зарлах, гарсан маргааныг шийдэх эрхийг эдэлдэг байна. Францын сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь Үндсэн хуулийн болон захиргааны хосолсон төрлийн тогтолцоотой. Захиргааны шүүх нь хараат бус ажиллах бөгөөд Төрийн зөвлөлд харъяалагддаг бөгөөд сонгуулийн бэлтгэл ажлын үеэс эхлэн маргааныг авч хэлэлцэж болно. Үндсэн хуулийн шүүх нь Төрийн зөвлөлийн сонгуулийн бүртгэл, сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааныг хянан үзсэн тодорхой шийдвэрийн талаарх маргааныг шийдвэрлэдэг. Сонгогчдын бүртгэлтэй холбоотой тодорхой хэргүүд дээр гомдлыг анхан шатны (Tribunal d'instance) шүүхэд хандан шийдвэрлүүлдэг, бөгөөд үүний дараагаар давж заалдах шатны шүүхэд мөн хандах боломжтой ба эдгээрийн шүүхүүд нь хоёулаа шүүхийн салбарт

хамаарч, гаргасан шийдвэрүүд нэгэн адил эцсийнх байдаг.

Үндсэн хуулийн болон захиргааны шинж чанар бүхий сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог Испани улсад хэрэглэдэг бөгөөд сонгуультай холбоотой эцсийн шийдвэрийг Үндсэн хуулийн шүүх гаргадаг. Энэ шүүх өмнө нь гаргасан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хянан үздэг. Өөр нэгэн жишээ нь Португал бөгөөд сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааныг Үндсэн хуулийн шүүх нь хэлэлцэн шийдвэрлэдэг байна. Төв болон Зүүн Европын ардчилсан шилжилтийг хийж буй олон тооны улс орнууд өөрийн Үндсэн хуулийн шүүхэд сонгуулийн үр дүнтэй холбоотой эцсийн шийдвэрийг гаргах эрхийг олгосон байдаг. Эдгээр улсуудын тоонд Болгар, Хорват, Молдав, Монтенегро, Румын, Армени, Словени, Чех, Гүрж, Словак зэрэг улсууд багтах ба эдгээр улсуудын Үндсэн хуулийн шүүх нь шүүх эрх мэдлийн салбарт хамаардаг байна. Индонези, Нигер улсуудад сонгуультай холбоотой маргаан, зөрчлийг Үндсэн хуулийн шүүх нь шийдвэрлэдэг бөгөөд Индонезид энэ шүүх нь шүүх эрх мэдлийн салбартаа хамаардаг.

Зарим улс орны сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд сонгуулийн үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой маргаан хуульд нийцсэн эсэхийг шалган тогтоохоос гадна Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг давхар магадлан шалгадаг шүүхийн харъяалалыг тодорхойлж, үүнийг Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллага (Үндсэн хуулийн шүүх, зөвлөл, эсхүл тухайн улсын дээд шүүх)-ын харъяалалд багтаасан байдаг. Жишээ нь Испани улсад Захиргааны хэргийн шүүх нь иймэрхүү үндсэн хуультай холбоотой асуудлыг Үндсэн хуулийн цэцэд хандан шийдүүлж болдог. Энэ нь авч хэлэлцэж буй асуудал, шийдвэр нь Үндсэн хуульд нийцсэн эсэх, Үндсэн хуулийн дагуу байна уу гэдгийг тогтоолгон, сонгуулийн дүнд өөрчлөлт оруулах тохиолдол байж болдог. Зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд Үндсэн хуулийн шүүх ийм төрлийн маргааныг хянан шийдвэрлэдэг бол зарим улс орнуудын хувьд Дээд шүүх ийм эрхтэй байдаг. Зарим оронд сонгуулийн асуудлыг хариуцсан тусгай шүүх байдаг. Жишээ нь Эквадор болон Мексик улсуудад ийм шүүх байдаг. Ийм байдлаар сонгуулийн маргаан шийдвэрлэх сайн туршлагыг нэвтрүүлсэн улс орнууд сонгууль Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх явдлыг хангах олон талын хамгаалалтыг бий болгодог.

Сонгуулийн маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэх талаар

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны түгээмэл бус ашигладаг төрөл нь сонгуулийн маргааныг эцэслэн шийдвэрлэх эрхийг бие даасан эсвэл шүүх эрх мэдлийн салбарын харьяа захиргааны хэргийн шүүхэд олгодог. Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа, шийдвэрийн эсрэг гаргасан сонгуулийн маргааныг зарим орнуудад уг маргааныг шийдвэрлэх харьяалал нь захиргааны хэргийн шүүхэд байдаг, мөн тухайн шүүхийн хараат бус, бие даасан

байдлыг бүрэн хангах замаар Францын уламжлалын дагуу захиргааны хэргийн шүүхэд уг маргааныг шийдвэрлэдэг (Төрийн зөвлөл).

Захиргааны хэргийн шүүх сонгуулийн маргааныг шийдвэрлэдэг тогтолцоотой орнуудын жишээнд Колумбулс багтах ба тус улсад ердийн шүүхийн бүтэц хамаардаггүй хараат бус Төрийн зөвлөл (Consejo de Estado) тухайн асуудлыг хариуцдаг. Өөр нэгэн жишээ нь Финланд улс бөгөөд Захиргааны хэргийн дээд шүүх нь (Korkein Hallinto-Oikeus) мужуудын захиргааны хэргийн шүүхийн (шүүх эрх мэдлийн салбарт хамаарах) гаргасан шийдвэрийг давж заалдах гомдлыг үндэслэн сонгуулийн хэргийг хянан шийдвэрлэх эрхтэй байдаг.

Иргэдийн гаргах гомдол Колумб улсад

Колумб улсад иргэд нь төрийн зөвлөлд хандан сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой гомдол гаргах эрхтэй бөгөөд үүний хүрээнд Сонгуулийн байгууллагын гаргасан шийдвэртэй холбоотой гомдлыг мөн гаргаж болдог. Тухайн гомдол нь үндэсний хэмжээний сонгуулийн санал тоололт, үр дүнг зарлах, эрхийг баталгаажуулахтай холбоотой байж болно. Төрийн зөвлөл нь сонгуулийн байгууллагын гаргасан шийдвэрийг цуцлах, өөрчлөх, засах эрх бүхий хараат бус захиргааны хэргийн шүүх юм.

Сонгуулийн маргааныг чиг үүргийн хувьд хараат бус сонгуулийн дагнасан шүүх шийдвэрлэх талаар

Ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн холбогдолтой маргааныг эцэслэн шийдвэрлэх эрхийг сонгуулийн асуудлыг хариуцсан дагнасан шүүхэд олгосон байдаг ба тухайн шүүх нь чиг үүргийн хувьд хараат бусаар ажиллаж, шүүх салбарын нэг хэсэг байж, эсхүл засаглалын гурван хэлбэрээс хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг. Хамгийн анх Уругвай улсад 1924 онд Сонгуулийн шүүх байгуулснаар сонгуулийн маргааныг сонгуулийн дагнасан шүүхээр шийдвэрлэдэг тогтолцоо эхэлсэн түүхтэй. 1925 онд Чили улсын Сонгуулийн баталгаажуулалтын шүүхийг (Tribunal Calificador de Elecciones) тус улсын Үндсэн хуулиар бий болгожээ. Энэ төрлийн сонгуулийн шүүх 20 дугаар зууны туршид хөгжин, улмаар Латин Америкын дийлэнх улсуудад байгуулагджээ. Үүнийг Латин Америкын орнуудын зүгээс дэлхий нийтийн улс төрийн шинжлэх ухаан, сонгуулийн хуулийн практикт оруулсан хувь нэмэр хэмээн үүнийг үзэж болох ба энэ туршлага нь Латин Америкийн бүс нутгийн орнуудад ардчиллыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмрээ оруулсан. Ялангуяа 1980-1990-ээд оны үеэр хамгийн өндөр үр дүнг үзүүлжээ. Энэ шүүх нь сонгуулийн дүнтэй холбоотой бүх асуудлыг эцэслэн шийддэг бөгөөд бусад шүүхийн болон үндсэн хуулийн шүүх энэхүү шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар шийдвэрлэх эрхгүй байдаг байна. Ийм тогтолцоо нь Чили, Доминикан, Эквадор, Мексик, Перу, Албани, Грек, Палестин, Өмнөд Африк, Швед зэрэг улсуудад хэрэгждэг. Албани, Грек, Мексик улсуудын сонгуулийн

шүүх нь тухайн улсын шүүх эрх мэдлийн салбарын нэг хэсэг байдаг бөгөөд дээр дурдсан бусад улсуудад энэхүү шүүх нь хараат бус байдлаар зохион байгуулагддаг. Гэхдээ энэ тогтолцоотой бүх улсуудын ийм төрлийн шүүх нь хараат бус чиг үүрэгтэй байдаг.

Сонгуулийн дагнасан шүүхээс гаргасан шийдвэрийг Үндсэн хуулийн зарчимд тулгуурлан Дээд шүүхэд давж заалдах боломжтой (Бразил, Сальвадор, Гондурас, Парагвай, Панам)-д байдаг. Мөн Үндсэн хуулийн шүүхэд уг сонгуулийн дагнасан шүүхийн шийдвэрийг давж заалддаг шүүхүүд (Боливи, Эквадор)-т байдаг. Түүнчлэн дээрх хоёр төрлийн тогтолцооны аль аль нь (Гватемал)-д байдаг бөгөөд үүнийг сонгуулийн зөрчил, маргаан шийдвэрлэх эрхийг шүүх эрх мэдлийн салбартаа хамааруулдаг, эсвэл Үндсэн хуулийн шүүхэд хамааруулдаг гэсэн ангилалд багтана. Энэхүү хэсэгт дурдагдсан сонгуулийн шүүхүүд нь (шүүх эрх мэдлийн салбарт хамаардаг Бразил, Парагвай улсуудаас бусад) хараат бус байдаг.

Энэхүү тогтолцоонд багтаагүй нэг төрлийн ангилал нь сонгуультай холбоотой бүхий л эцсийн шийдвэрийг гаргах эрхтэйгээс гадна сонгуулийн ажиллагааг зохион байгуулах, удирдах захиргааны чиглэлийн чиг үүргийг хэрэгжүүлдэг Сонгууль зохион байгуулах эрх бүхий этгээдтэй ижил төрлийн үүргийг хэрэгжүүлдэг сонгуулийн дагнасан шүүх юм. Ийм шүүхтэй орнуудын жишээнд Коста Рика, Никарагуа, Уругвай улсууд хамаарна. Энэ тогтолцооны онцлог нь тусгайлан сонгуулийн шүүх байгуулсан эсэхээс үл хамаардаг. Энэ байгууллага нь сонгууль удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй, үйл ажиллагаа нь бие даасан, хараат бус байдаг бөгөөд сонгуулийн маргааны талаарх эцсийн шийдвэрийг энэ байгууллага баталгаажуулдаг байна.

Сонгуулийн байнгын ажиллагаатай дагнасан шүүх байх нь мэргэжлийн өндөр түвшинд асуудлыг судлан, энэ салбарын орчин үеийн хөгжил, дэвшилд тулгуурлан энэ төрлийн маргааныг шийдвэрлэх боломжийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэртэй бөгөөд сонгуулийн аль ч үе шатанд (эхний болон дараагийн аль ч үед) маргааныг түргэн шуурхай шийдвэрлэхэд чухал гэж үздэг. Гэхдээ энэ нь маш их зардал өндөртэй байж болох юм. Сонгуультай холбоотой гомдол, маргаан цөөн гардаг улс орнуудад сонгуулийн байнгын шүүхтэй байх тогтолцоог төдийлөн дэмждэггүй хандлагатай байдаг.

Сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагад шүүхийн эрх мэдлийг олгодог Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо

Энэ төрлийн тогтолцооны хувьд Сонгууль зохион байгуулах эрх бүхий этгээд нь сонгууль удирдан зохион байгуулах болон сонгуулийн ажиллагааны бүхий л захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ сонгуулийн ажиллагааны хүчин төгөлдөр эсэхийг баталгаажуулах болон сонгуулийн талаарх маргааныг

хянан шийдвэрлэх шүүхийн адил эрхтэй байдаг. Энэхүү загварыг үндсэндээ Латин Америкын орнуудад авч хэрэгжүүлсэн. Энэ төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоогоор маргааныг зөвхөн эцэслэн шийдвэрлээд зогсохгүй мөн сонгууль хүчин төгөлдөр эсэх талаар эцсийн шийдвэр гаргадаг бөгөөд уг шийдвэрийг аливаа шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллага хянах эрхгүй байдаг. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрхийг олгодог улс орнуудын хараат бус сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагууд нь Никарагуа улсын Сонгуулийн дээд зөвлөл (Consejo Supremo Electoral), Коста Рика улсын Сонгуулийн дээд шүүх (Tribunal Supremo de Elecciones) болон Уругвай улсын Сонгуулийн шүүх болон Туркын Сонгуулийн дээд зөвлөл (Yüksek Seçim Kurulu Başkanlığı) зэрэг байгууллагуудыг нэрлэж болно. Никарагуа улсын Үндсэн хуулиар Сонгуулийн дээд зөвлөлийг сонгуулийн засаглалыг хэрэгжүүлэх байгууллага гэж заажээ. Коста Рика улсын Үндсэн хуулиар Сонгуулийн дээд шүүхэд энэхүү маргаан шийдвэрлэх эрхийг олгосон байдаг бол Уругвай улсын Үндсэн хуулийн дагуу Сонгуулийн шүүхийг байгуулан, түүний бүтцийг тогтоон үүнийг дөрөв дэх засаглал хэмээн хууль ёсоор заасан байдаг. Эдгээр улсын сонгуулийн шүүхийн шүүгчид болон гишүүд нь шүүх эрх мэдлийн салбарын шүүгчдийн адил ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдсан байдаг. Тэдгээр нь сонгуулийн үйл ажиллагааг зохион явуулах захиргааны эрх, үүргийг хэрэгжүүлдэг гэдгээрээ хараат бус сонгууль зохион байгуулах эрх этгээд гэдэгт хамаарахын зэрэгцээ мэргэжлийн талаас нь авч үзвэл шүүхийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага гэж авч үзэх боломжтой. Сонгуулийн дагнасан шүүхтэй харьцуулбал шүүх эрх мэдэл бүхий сонгуулийн байгууллага нь сонгуультай хамааралтай шийдвэр гаргадаг бүх байгууллагын үйлдэл, үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой маргааныг шийдвэрлэх эрхгүй зөвхөн харин сонгуулийн доод шатны байгууллагын шийдвэртэй холбоотой маргааныг шийдвэрлэдэг. Түүнчлэн гаргасан шийдвэрийг нь Дээд шүүх эсвэл Үндсэн хуулийн шүүх хянан үздэг сонгуулийн дагнасан шүүхээс ялгаатай нь шүүх эрх мэдэл бүхий сонгуулийн байгууллагын шийдвэр нь эцсийнх байдаг. Ерөнхийдөө шүүх эрх мэдэл бүхий сонгуулийн байгууллага нь пирамид бүтэцтэй байдаг. Дээд байгууллага нь үндэсний хэмжээнд өндөр түвшний байгууллагадаа төвлөрсөн байдлаар хамаардаг харин бусад дунд түвшний байгууллагууд нь дараагийн шатны байгууллагадаа хамаардаг. Ихэнх тохиолдолд тэдгээр нь нутаг дэвсгэр, засаг захиргаа, улс төр болон сонгуулийн тойрог, хэсгүүдийн зарчмаар хуваагдаж (ихэнхдээ бүсийн, улсын орон нутгийн, хотын, дүүргийн хэмээдэг) эцсийн шат нь иргэд ирж саналаа өгдөг санал авах байрууд хүртэл үргэлжилдэг.

Туркын үндсэн хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар Сонгуулийн дээд хороо нь (Yüksek Seçim Kurulu Başkanlığı) сонгуулийг эхнээс нь дуустал нь шударга, эмх цэгцтэй явуулах бүхий л үүргийг хүлээхээс гадна хууль бус шийдвэрүүдийн талаар гарсан маргааныг мөрдөн шалгах, санал хураалтын үеэр болон дараа гарсан гомдол, маргааныг шийдвэрлэх болон Туркын үндэсний ассемблейд сонгогдох гишүүдийг баталгаажуулдаг. Тус хорооны гаргасан шийдвэрт гомдол гаргадаггүй байна.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрхийг хараат бус сонгуулийн байгууллагад олгож, энэ байгууллага нь нилээд амжилттай бөгөөд үр дүнтэйгээр ажиллаж байгаа тохиолдолын жишээнд Коста Рика болон Уругвай улсууд хамаарна. Эдгээр улсуудад өөрийн гэсэн дагаж мөрдөх хэм хэмжээний тогтолцоог бий болгон, хуулийн хэрэгжилтийн ханган ажиллах гишүүдийн үйл ажиллагааны чадварыг сайн бүрдүүлжээ. Энэхүү хоёр улс нь өөрийн сонгуулийн маргааны шийдвэрлэх тогтолцоондоо ардчиллыг хэрэгжүүлж, шилдэг туршлагыг бий болгож чадсан жижиг улс орнуудад хамаарна. Тэдний энэхүү амжилтад нөлөөлж буй нэг хүчин зүйл нь тухайн улсуудад улс төрийн соёл нилээд өргөн хүрээнд нэвтрүүлж бий болгосон явдал бөгөөд тэд Латин Америк дахь ардчиллын зарчим болон үнэт зүйлийг бүрдүүлэхийн төлөө хамгийн ихээр хичээл зүтгэл гаргаж буй орнууд юм. Эдгээр орнуудын сонгуулийн шүүхүүд нь олон жилийн туршид үйл ажиллагаа явуулахдаа энэхүү улс төрийн соёлыг бий болгож чаджээ.

Хэдийгээр хараат бус байгууллага ч гэсэн эрх мэдлээ урвуулан ашиглаж болзошгүй, ялангуяа энэ байгууллагын шийдвэрт гомдол гаргах боломжгүй учраас сонгуулийн байгууллагад шүүхтэй адил эрх мэдлийг бүрэн хэмжээгээр эдлүүлэх талаар сайтар судлан, нухацтай авч үзэх шаардлагатай. Сонгуулийг зохион байгуулах болон сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх үүргийг зөвхөн нэг байгууллага хэрэгжүүлэх нь өөрөө эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг бүрдүүлдэг.

Түр шинжтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага (ad hoc body)-аар сонгуулийн маргааныг шийдвэрлүүлдэг тогтолцоо

Түр зорилгоор болон шилжилтийн үед байнгын бус үйл ажиллагаа явуулдаг байгууллагаар сонгуулийн маргааныг шийдвэрлүүлдэг тогтолцоог чөлөөт, шударга сонгуулийг баталгаажуулах зорилгоор ноцтой зөрчил, мөргөлдөөн болсон улс орнуудад олон улсын байгууллагын санхүүжилтээр зохион байгуулдаг.

Олон улсын байгууллагын оролцоотой байгуулагддаг түр сонгуулийн байгууллага

Кампучи улсад 1993 онд, Босни Герцеговина улсад 1996 онд, Балбад 2008 онд, Зүүн Тиморт 2001 онд, Афганистанд 2005 онд амжилттай хэрэгжүүлж байжээ. Ийм төрлийн тогтолцооны нэг чухал шинж нь сонгуулийн маргааныг түр зуурын байгууллага шийдвэрлэх мөн чанарт тулгуурлсан байдаг. Тухайн улсад тогтвортой, байнгын сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо бий болох хүртэл буюу шилжилтийн үед тусгайлсан нэг болон хэд хэдэн сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлүүлэхэд ашигладаг. Ийм төрлийн хувилбарыг нэг болон хэд хэдэн олон улсын байгууллагууд санхүүжүүлдэг. Тухайлбал, НҮБ, Европын, Америкын улсуудын

холбоо зэрэг байгууллагууд зөрчил, мөргөлдөөний дараах шилжилтийн нөхцөл байдалтай орнуудад ийм төрлийн санхүүжилт үзүүлдэг. Түр байгууллага нь ихэнхдээ олон улсын байгууллагуудаас томилогдсон гишүүдийг оруулдаг. Гол зорилго нь ямар нэгэн бүлэг, салбарыг үл орхигдуулсан чөлөөт, шударга, бодит сонгуулийг явуулахад оршино.

Тухайн улсад үндэсний институт байдлаар байгуулагддаг түр байгууллага

Зарим улс орон өөрийн шилжилтийн үеийн дотоод асуудлаа шийдвэрлэх зорилгоор нэг болон хэд хэдэн сонгуультай холбоотой онцлог маргааныг шийдвэрлэх эрх бүхий түр байгууллагыг байгуулдаг. Уг байгууллагыг улс төрийн гол хүчнүүдийн гэрээ хэлэлцээр болон зөвшилцлийн дагуу байгуулдаг. Ийм гэрээ, зөвшилцлийг ноцтой зөрчил, мөргөлдөөний улмаас сонгуулийн байгууллагын чиг үүргийнхээ дагуу ажиллаж чадахгүй болсон болон Үндсэн хуулийг хэрэгжүүлж чадахгүй болсон тохиолдлуудад байгуулдаг. Ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь Үндэсний хууль тогтоомжид заасны дагуу шилжилтийн, үндсэн хуулийн эсвэл бусад хуулийн болон мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд байгуулсан эв нэгдлийн гэрээ, хэлэлцээр зэргийг үндэслэдэг. Ийм байгууллагыг тухайн улсын иргэдийн оролцоотойгоор сонгуулийг шударга, чөлөөтэй, хуулийн дагуу явуулах зорилгоор зохион байгуулдаг.

Ийм нөхцөл байдал Балба улсад болсон. Энхийн гэрээ байгуулсны дараагаар Ассемблейн шүүхийг 2006 оны Ассемблейн сонгуулийг зохион явуулахад зориулан байгуулж, тухайн сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэж байжээ. Үүний үр дүнд хоёр жилийн хугацаатай Ассемблейг байгуулан энэ хугацаанд шинэ Үндсэн хуулийг боловсруулах үүргийг хүлээлгэсэн байна. Эцэст нь тусгайлсан түр шүүхийг Дээд шүүхийн гишүүн гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд үүнтэй хамт сонгууль зохион байгуулах үүрэг бүхий байгууллагыг байгуулан ажиллуулсан.

Ийм төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны гол шинж нь түр бөгөөд шилжилтийн шинжтэй байдаг. Түр байгууллага нь тухайн сонгуультай холбоотой маргааныг сонгуулийн үед болон тодорхой үйл ажиллагаа явуулах хугацаандаа шийдвэрлэдэг. Энэ төрлийн сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь сонгуулийн ажиллагаа, үр дүнгээс нь хамааралтайгаар ноцтой зөрчил, мөргөлдөөн үүсэж, үүнээс үүдэн гарсан маргааныг дараа нь тусгайлан шийдэх шаардлага бүхий нөхцөл байдлаас ялгаатай. Үүний жишээнд АНУ-д 1876 онд болсон хэрэг явдал, 2007 онд Кени улсад болсон хэрэг явдал зэрэг багтана. Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд хуулийг даган мөрдөж, хуулийг дээдлэх нь чухал хэдий ч улс төрийн намуудад сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөх тал дээр үүссэн зөрчлийг хуульд нийцүүлэн шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал байдаг. Энэ тохиолдолд тухайн гарч болох үр дагавар, хүчирхийллээс зайлсхийхийн тулд ийм төрлийн маргааныг

шийдвэрлэх шүүхийн бус арга замыг ашиглах нь үр дүнтэй байдаг.

Олон улсын практикт сонгуулийн маргааныг сонгуулийн үе шатуудтай холбон дор дурдсанаар ангилдаг байна:

- Сонгуулийн өмнөх буюу сонгуулийн бэлтгэлийг хангах үед гарах маргааны төрөл:

Сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд сонгуулийн хуулийн төслийг бэлтгэх, боловсруулах, сонгуулийн ажилтнуудыг сонгох болон сургах, сонгуулийн байгууллагаас төлөвлөгөөгөө гаргах, гарч буй маргааныг шийдэх зэрэг олон тооны ажлыг хамруулдаг. Эдгээр асуудлын зарим нь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хүрээнд хамаарч байдаг, тухайлбал, сонгуулийн хэсэг, тойргийн хил хязгаарыг тогтоох, улс төрийн намуудын бүртгэлийг баталгаажуулах, бүртгэхээс татгалзах эсэх, сонгогчдын бүртгэлийг шинэчлэх, сонгуулийн ажиллагааны тухай мэдээллийг түгээх, иргэний боловсролыг дээшлүүлэх зэрэг асуудал хамаардаг. Мөн улс төрийн намуудын дотоод ардчилалтай холбоотой үйл ажиллагааны хүрээнд хамаарах намын дотоод дүрэм, журмыг батлах, намын удирдлага болон нэр дэвшигчдийг сонгох, намын гишүүнээс хасах, хариуцлага тооцохтой холбогдон гарах маргаан зэргийг энэ үе шатанд хамааруулжээ.

- Сонгууль явагдах үед гарах маргааны төрөл:

Үүнд сонгуульд нэр дэвшүүлэх, нэр дэвшигчдийн бүртгэх, нэр дэвшигчийн жагсаалт гаргах, сонгуулийн кампант ажил явуулах, санал хураах байруудыг засах, сонгуулийн ажилтнуудыг томилох, ажиглагч нарт гэрчилгээ олгох, санал хураалт явуулах процесс, санал тоолох, сонгуулийн дүнг зарлах болон хэвлэн нийтлэх зэрэг үйл ажиллаганы хүрээнд гарсан аливаа зөрчил, маргааныг хамруулсан.

- Сонгуулийн дараах үед гарах маргааны төрөл:

Үүнд улс төрийн намууд санхүүжилтээ яаж шийдвэрлэсэн, хэрхэн ашигласан, нэр дэвшигчдийн кампант ажлын зардлын тайланг хянан шалгах, сонгуулийн тойргуудын хамрах хүрээ, хил хязгаарыг хянах зэрэг үйл ажиллагаатай холбоотой маргааныг хамруулжээ. Зарим улсад тухайн сонгуультай холбоотой шууд ардчиллын төрөлд хамаарах бүх нийтийн санал асуулга болон дахин сонгууль явуулахтай холбоотой үйл ажиллагаа сонгуулийн дараагийн шатанд хийгдэх тохиолдол байдаг байна. Сонгуулийн дараах үе шатанд сонгуультай холбоотой гардаг маргааныг дараагийн сонгуулийг сайжруулах, түүний тогтвортой байдлыг хангахад нөлөөлдөг гэж үздэг.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх зарчмууд

- Гомдлыг хуульд заасан хугацаанд гаргах зарчим

Хэдхэдэнулсадсонгуулийнүеэргарсаналиваамаргаантайасуудлыгсонгуулийн дүн гарахаас өмнө л гаргаж ирж, шийдвэрлүүлэх ёстой бөгөөд хэрэв тухайн хугацаанд гомдол гаргаагүй бол энэ нь сонгуулийн дүнг хүчингүй болгох үндэслэл болдоггүй ажээ. Энэ зарчим нь тухайн гарч буй зөрчил нь тэр үедээ л хүчинтэй байх бөгөөд энэ талаарх гомдлыг нэн даруй гаргахыг шаарддаг. Сонгуулийн өмнөх үе шатанд гомдол гаргаагүй бол тухайн асуудлын нөхцөл байдлаас шалтгаалан зарим тохиолдолд дараагийн үе шатанд уг гомдлыг шийдвэрлүүлэх бодит үндэслэлтэй нөхцөлд л зөвхөн тухайн гомдлыг дараагийн үе шатанд хэлэлцэн шийдвэрлэж болдог.

- Хэрэгжиж байгаа үйлдэл, үйл ажиллагааг түдгэлзүүлэхгүй байх зарчим

Сонгуулийн үр дүнд байгуулагддаг аливаа төрийн байгууллагууд нь хуульд заасан сонгуулийн хугацаанаас шалтгаалж бүрэн эрх нь эхэлж, дуусгавар болдог учраас сонгуулийн ажиллагааг тасалдуулж болдоггүй, түүнийг нэгэнт эхлүүлсэн бол заавал дуусгах шаардлага байдаг. Үүний үр дүнд сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцоонд хэрэглэгддэг нийтлэг зарчим гарч ирдэг. Энэ нь гомдлыг шийдвэрлэхдээ тухайн үйлдэл, үйл ажиллагааны хэрэгжилтийг хүчингүй болгон түдгэлзүүлэхгүй байх зарчим байдаг. Ийм учраас тухайн гомдолтой холбоотой асуудал албан ёсоор шийдэгдэх хүртэл маргаж буй үйл ажиллагаа үргэлжилдэг.

- Гомдлыг богино хугацаанд шийдвэрлэх зарчим

Аливаа хүчирхийлэл, үл ойлголцлоос урьдчилан сэргийлэхийн тулд сонгуультай холбоотой гомдлыг богино хугацаанд яаралтай шийдвэрлэх нь эрүүл практикийг бий болгоход чухал үүрэгтэй гэж үздэг.

Сонгуулийн хариуцлага тооцох журам: Шийтгэл ногдуулах талаар

Сонгуулийн холбогдолтой эрүүгийн гэмт хэргийг ихэвчлэн эрүүгийн шүүх шийтгэл ногдуулдаг харин зарим улсад жишээ нь Панам улсад тусгайлсан сонгуулийн шүүх ийм төрлийн хариуцлага ногдуулдаг.

Зарим зүй ёсны сонгуулийн тогтолцоонд захиргааны хариуцлагыг сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага ногдуулдаг бөгөөд эдгээр байгууллага нь шүүхээр маргаан хянан шийдвэрлэхтэй адилаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг бөгөөд ийм ажиллагааг сонгуулийн маргааныг шийдвэрлэх этгээдээс өмнөх ажиллагаа (урьдчилан шийдвэрлэх ажиллагаа) гэж үздэг. Харин зарим улсад

зөвхөн шүүх л эдгээр хариуцлагыг ноогдуулах эрхтэй байдаг. Харин нийтийн эрх зүйн системтэй улсуудад эрүүгийн шүүх ерөнхийд нь хэргийг авч үзээд захиргааны болон эрүүгийн хариуцлага ногдуулах шаардлагатай эсэхийг ялгахгүйгээр иргэний шүүх, захиргааны шүүх эсхүл, сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий этгээд өөрөө хянан шийдвэрлэх ёстой гэж үзвэл тэдгээр байгууллагад шилжүүлдэг.

Эрүүгийн хариуцлагын талаар

Зарим сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд, жишээ нь Англид ялалт байгуулсан нэр дэвшигч нь авилгалын хэрэгт буруутай гэж тооцогдсон болон бусад хууль бус үйлдэл хийсэн нь нотлогдсон бол тухайн этгээд гэмт хэрэгт буруутгагдан ял авсан, үгүй эсэхээс үл хамаарч тухайн нэр дэвшигчид хамааралтай сонгуулийн үйл ажиллагаа хүчингүй болдог. Бусад улсад (жишээ нь Киргизстан) сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага болон сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага нь эрүүгийн шүүхээс тухайн үйл ажиллагааг гэмт хэрэг гэж тогтоосон тохиолдолд түүнийг сонгуулийн үр дүнд нөлөөлөх эсэхийг шийдвэрлэх мөн сонгуулийн хүчинтэй эсэхийг зарлах эрхтэй байдаг.

Сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн талаарх хуулийн зохицуулалтыг үндэсний эрх зүйн тогтолцооны хувьд ямар хуульд хамааруулан авч үзэх талаар хоёр үндсэн бодлого, арга зам байдаг.

Эхнийх нь ийм төрлийн гэмт хэргийг эрүүгийн хуулийн зүйл заалт болгон оруулдаг бол нөгөө нэг нь эрх зүйн тогтолцооны хувьд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх хуулийн зохицуулалтыг сонгуулийн хуульдаа оруулж өгсөн байдаг. Эхний арга замыг баримтлагчид нь сонгуулийн хууль байнга өөрчлөгдөж байдаг тул сонгуультай холбоотой гэмт хэргийн талаарх хуулийн зохицуулалтыг харьцангуй тогтвортой үйлчилдэг эрүүгийн хуульд тусгаж өгөх нь хамгийн зөв хэмээн үздэг. Бусад нь сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг, зөрчил нь сонгуулийн байнга өөрчлөгдөж байдаг динамикаас өөр байж болохгүй гэдэг. Улмаар энэхүү сонгуулийн гэмт хэргийн талаарх тодорхойлолт сонгуулийн ерөнхий зохицуулалтыг тусгасан эрх зүйн орчин өөрчлөгдсөн үед мөн л дагаж өөрчлөгдөх шаардлагатай бөгөөд сонгуулийн хууль болон сонгуулийн хуулийн хариуцлагатай холбоотой заалтууд хоорондоо уялдан тогтмол өөрчлөлт, засварууд орох нь зөв гэж үздэг.

Улс бүрийн түүхэн болон нийгэм-улс төрийн нөхцөл байдал нь сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийг тодорхойлоход чухал нөлөө үзүүлнэ. Тухайн орны улс төрийн соёл, сонгуулийн практик нь тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх үү гэдэг бас нөлөөлдөг. Учир нь тухайн тогтсон улс төрийн соёлд эрх чөлөө, тэгш байдлыг хэрхэн ойлгодог болохоос хамаарч зарим үйлдлийг зөвшөөрөх эсвэл хориглодог. Нэг улс орны хэмжээнд үүнийг ялгаатайгаар, өөр өөрөөр авч үзэх тохиодол байж болдог.

Жишээ нь зарим улсад нэр дэвшигчид болон улс төрийн намууд сонгогчдыг санал авах байр руу зөөсөн бол эрүүгийн хариуцлага ногдуулдаг. Ийм төрлийн хариуцлагыг бодит өрсөлдөөний дагуу сонгууль явагдаггүй улсуудад түгээмэл хэрэглэгддэг. Өмнөх засгийн эрх баригч нам нь бусдаасаа хүний нөөц болон бусад эх үүсвэр сайтай байдгаас шалтгаалж санал худалдан авах, сонгуулийн үр дүнд нөлөөлөх оролдлогыг гаргадаг.

Сонгогчдыг зөөвөрлөх нь сонгох эрх чөлөөнд ноцтой хор хохирол учруулдаг үйлдэл гэж үздэг бөгөөд үүнийг мөн л сонгуулийн үр дүнд нөлөөлөх, санал худалдах авах үйлдэлтэй холбоотой гэж үздэг. Харин Английн түүхэнд сонгогчдыг санал авах байр руу тээвэрлэхийг дээрхээс өөрөөр авч үздэг байжээ: хүчтэй намуудын зүгээс харьцангуй ядуу иргэд баячуудын эсрэг зогсох боломжийг олгодог- энэ хугацаанд тээврийн компанийн эзэд сонгогчдыг санал өгөхөд нь хүргэж өгч тусалдаг байжээ. Үүнийг сонгуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа нэг хэлбэр гэж үзэн сонгуулийн хуулийн дагуу үйлдэлд тооцогддог байсан. Цаашлаад, сонгууль нь илүү нээлттэй явагддаг олон орнуудад сонгогчдыг тээвэрлэхийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд учир нь энэ нь улс төрийн өрсөлдөөний хууль ёсны байдлыг хангадаг нэг хэсэг хэмээн үздэг байна.

Олон улс орнуудад сонгуультай холбоотой гэмт хэргийг байцаан шийтгэх ажиллагаа нь бусад гэмт хэргийг байцаан шийтгэх ажиллагаатай ижил хэлбэрээр явагддаг. Прокурор эсвэл үүнтэй дүйцэх албан тушаалтан тухайн гэмт хэргийг мөрдөх, гэмт хэрэгт холбогдогч этгээдийг гэмт хэрэгт буруутай эсэхийг магадлан шалгах улмаар шүүхэд шилжүүлэн, эрүүгийн хэрэгт яллах дүгнэлт гаргах үүргийг хүлээнэ. Эрүүгийн хэргийн шүүгч нь шүүх хурлыг явуулж тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэдгийг нь нотлосон тохиолдолд ихэнхдээ энэ гэмт хэрэгт хорих ял ногдуулдаг. Зарим улсад тангарагтаны гаргасан шийдвэрийг мөн харгалзан үзнэ.

Зарим улсуудад сонгуулийн асуудлыг хариуцсан прокурор, зарим улсад тусгайлсан байгууллага ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Мексик улсад Сонгуулийн тусгай прокурорын газар байдаг бөгөөд энэ нь Ерөнхий прокурорын харьяанд байдаг. Панам улсад Сонгуулийн гэмт хэргийн ерөнхий прокурорын алба ажилладаг бөгөөд энэ нь хараат бусаар сонгуулийн холбогдолтой гэмт хэргийг мөрдөн шалгадаг.

Хэдийгээр сонгуулийн холбогдолтой гэмт хэргийг эрүүгийн шүүх шийддэг ч зарим улсад сонгуулийн маргаан шийдвэрлэх тусгай байгууллага нь үүнийг мөрдөн шалгах эрхийг эдэлдэг. Жишээ нь Латин Америкын орнууд болох Бразил болон Панам улсад ийм төрлийн байгууллага байдаг.

Захиргааны хариуцлагын талаар

Сонгуулийн ажиллагаатай холбоотой захиргааны зөрчил гэж гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, тухайн этгээд нь сонгуулийн болон бусад захиргааны хуулиар зохицуулсан сонгуулийн дүрэм, журмыг зөрчсөн буруутай үйлдлийг хэлдэг. Энэ тохиолдолд эрх чөлөөг нь хасахаас бусад шийтгэл ноогдуулдаг. Ийм төрлийн зөрчлийг ихэнхдээ сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэдэг бөгөөд иргэний буюу эх газрын эрх зүйн системтэй орнуудад түгээмэл байдаг. Захиргааны хариуцлагыг сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллага нь бодит нөхцөл байдал, баримт материал цуглуулах ажиллагааг хийдэг бөгөөд үүнийг маргааныг шийдвэрлэхийн урьдчилсан процесс гэж үздэг. Харин зарим улсад захиргааны хариуцлагыг зөвхөн шүүх ногдуулдаг. Энэ нь үндсэндээ нийтийн эрх зүйн системтэй улсуудад хэрэглэгддэг бөгөөд эрүүгийн шүүх, иргэний шүүх, захиргааны хэргийн шүүх заримдаа сонгуулийн маргаан шийдвэрлэх тусдаа байгууллага ч хянан шийдвэрлэж болдог.

Санхүүгийн хариуцлагын талаар

Санхүүгийн хариуцлага буюу торгууль нь тухайн буруутай үйлдлийг дахин гаргуулахгүй хэмээн хангалттай өндөр байх ёстой гэсэн төрийн бодлогыг олон орнууд хэрэгжүүлдэг. Хэрэв торгуулийн хэмжээг билэгдлийн шинжтэй, бага хэмжээгээр тогтоосон тохиолдолд тухайн зөрчлийг гаргаж буй этгээд торгууль төлөх, зөрчил гарахын хоорондын зөрүү төдийлөн ялгаагүй юм байна гэж үзэн торгууль төлөөд зөрчил гаргах нь өөрт нь бага зардалаар илүү үр дүнд хүрч болно гэж тооцдог байна. Иймээс тухайн үйлдлийн гарах үр дүнгээс илүү өндөр торгуулийн шийтгэлийг тухайн зөрчилд хүлээлгэх зарчмыг баримтлах нь чухал гэж үздэг. Үүнтэй холбоотойгоор хариуцлага ногдуулах хугацааг тооцоолох мөн чухал асуудал юм.

Франц улсад 2000 оны тэгш байдлын хуулийн хүрээнд сонгуулийн хууль тогтоомждоо эмэгтэйчүүдийн квотыг нэмж оруулжээ. Энэхүү хуулийн заалтад заасан тооны эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлээгүй улс төрийн намуудад торгууль ноогдуулж, төрөөс тэдэнд олгох санхүүжилтыг бууруулах арга хэмжээг авахаар заажээ. Францын зарим улс төрийн намууд үүнийг даган мөрдөлгүйгээр төлөх торгуулийн хэмжээг бага хэмээн үзсэн тул хуульд заасан тооны эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэлгүй, харин торгууль төлсөн байна. Францаас гадуур орших нутаг дэвсгэрт ч гэсэн мөн хуулийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Шинэ Каледонд ч хэрэгжсэн байна. Харин Шинэ Каледоны улс төрийн намууд нь Францын намуудаас ядуу тул хуульд заасан тооны эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлжээ. Үүний үр дүнд Шинэ Каледоны хууль тогтоох байгууллагад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн төлөөлөл бараг ижил болсон бөгөөд эмэгтэйчүүд 44.4%-ийг эзэлсэн бол Францад энэ хэмжээ дөнгөж 18.9% байжээ (2010 оны 2 сарын байдлаар). Эндээс харахад нэг нутаг дэвсгэрт тохирох систем нь нөгөө нутаг дэвсгэрт тэр бүр ижил байдлаар хэрэгждэггүй, тохирдоггүй байна.

Улс төрийн хариуцлагын талаар

Сонгуулийн хуулийг зөрчсөн тохиолдолд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ улс төрийн гэж хэлж болох зарим төрлийн хариуцлагыг хүлээлгэж болдог. Тодорхой сонгуулийн ажиллагаатай холбоотой ноцтой зөрчлийг хууль тогтоох байгууллага, бусад улс төрийн хурал, чуулган, төрийн өндөр албан тушаалтан тухайлбал, сайд, Засаг дарга, хууль тогтоогч, шүүгч болон сонгууль зохион байгуулах эрх бүхий этгээдээс үйлдсэн бол энэ төрлийн улс төрийн хариуцлагыг ногдуулдаг. Жишээ нь нийтийн эрх зүйн тогтолцоотой орнуудад импичмент буюу өндөр албан тушаалтныг хариуцлага алдсаных нь төлөө буруутгаж шүүхэд дуудах процедурыг хэрэглэдэг уламжлал байдаг. Өөр нэг жишээ нь juicio político буюу улс төрийн шүүх бөгөөд үүнийг Латин Америкын хэд хэдэн оронд хэрэглэн хууль тогтоох байгууллагын өндөр албан тушаалтныг албан тушаалаас нь огцруулах, төрийн алба хаших эрхийг тодорхой хугацаагаар хасах зэрэг хариуцлага ногдуулдаг байна.

ТАВ. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГЫГ МОНГОЛ УЛСАД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХ ХУВИЛБАРЫН ТАЛААРХИ ЗӨВЛӨМЖ

Судалгаанаас дүгнэхэд аливаа улс орнуудын сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь тухайн улсынхаа түүх, нийгэм-улс төрийн нөхцөл байдал, эрх зүйн уламжлалт тогтолцооноос хамаарч байдаг. Ийм учраас нэг улсын сургамж, туршлагыг нөгөө улсын түүх, нийгэм, улс төрийн өөр нөхцөл байдал болон өөр эрх зүйн тогтолцоонд тохируулан шууд хуулбарлан хэрэглэх боломжгүй. Энэ судалгаанд дурдсаны дагуу олон улс орнууд хэдийгээр өөр өөр эрх зүйн тогтолцоотой ч гэсэн сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцоо нь ижил төстэй шинжүүд байдаг. Иймд манай улсын хувьд ч гэсэн хэдийгээр эх газрын буюу Ром-Германы эрх зүйн тогтолцоотой ч гэсэн Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой орны сонгуулийн маргаан шийдвэрлэх зарим сайн туршлагыг авч хэрэгжүүлэх боломжтой юм.

Иймд эрх зүйн тогтолцооны ялгаатай болон ижил байдлыг харгалзахгүйгээр манай улсын хувьд өөрийн улсын нийгэм, улс төрийн онцлог нөхцөл байдалдаа тулгуурлан сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоогоо боловсронгуй болгохдоо дор дурдсан хувилбарыг авч хэрэгжүүлж болохоор байна:

1. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх /сонгуулийн маргааныг урьдчилсан байдлаар шийдвэрлэх/ эрх бүхий байгууллага бий болгох талаар

Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрүүл болон шилдэг туршлага нь аливаа

сонгуулийн үйлдэл, үйл ажиллагаа, шийдвэрийг хянах эрх бүхий этгээдийн ажиллах боломжийг хуульд тусгайлан заах явдлаар илэрдэг гэж үздэг байна. Үүнийг зарим олон улсын баримт бичгүүдэд хүний эрхийн үндсэн хэсэг болгон оруулсан байдаг. Энэ нь сонгуулийн өмнөх, сонгуулийн үеэр, сонгуулийн дараах зэрэг аль ч үе шатанд гарсан аливаа сонгуулийн үйлдэл, үйл ажиллагаа, шийдвэр нь хяналтанд байх баталгааг хангах зорилготой байдаг. Ялангуяа сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагыг сонгуулиас бусад үед үйл ажиллагаа явуулахгүй байх тухай заалтыг хуульд тусгахыг чухалчилдаг ажээ. Энэ тохиолдолд сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагаас өөр байгууллага сонгуулийн өмнөх болон дараах үед гарсан маргааныг шийдвэрлэх шаардлагатай болно. Иймээс сонгуулийн маргаан шийдвэрлэх байнгын ажиллагаатай болон хараат бус байгууллагыг бий болгох нь сайн практиктай сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд тооцогддог тул манай улс ч мөн адил энэ практикийг авч хэрэгжүүлж болох юм.

2. Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлээд гарах үр дагавар Сонгуулийн хуулиудад тодорхой зааж өгөх талаар

Сонгуулийн маргааныг шийдвэрлэх албан ёсны механизмуудыг а/сонгуулийн маргааныг засан залруулах үүрэгтэй, б/хариуцлага хүлээлгэх, шийтгэл ноогдуулах үүрэгтэй гэдгээр хооронд нь нарийвчлан зааглаж сонгуулийн хуулиудад дор дурдсанаар оруулж өгөх зүйтэй гэж үзэж байна:

а/Сөрөг үр дагаварыг засан залруулах шинжтэй үр дагавар. Үүнд:

- сонгуулийн хууль бус үйлдэл, үйл ажиллагааг хүчингүй болгох, өөрчлөх;
- зөрчил гарсаныг тогтоох;
- тухайн хууль бус үйлдлээс шалтгаалан зөрчигдсөн сонгуулийн эрхийг хамгаалах болон сэргээн тогтоох...

б/Хариуцлага хүлээлгэх чиглэлийн арга хэмжээ нь сонгуулийн зөрчил гаргасан байгууллага, иргэнд хариуцлага хүлээлгэх. Үүнд:

- захиргааны хариуцлага;
- иргэний хариуцлага;
- эрүүгийн хариуцлага.

3. Сонгуулийн маргааны шийдвэрлэхэд чухал зарим зарчмыг сонгуулийн хуулиудад оруулах талаар

Захиргааны процедур нь хэт удаан үргэлжилж, сонгууль дууссаны дараагаар буюу тухайн зөрчил гаргасан этгээд нь аль хэдийн ялалт байгуулсан хойно шийдвэр гарч, хариуцлага тооцохоор байвал энэ нь хуулийг зөрчөөд бай гэсэн уриалга шиг л болно. Хариуцлага ногдуулах захиргааны хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуульд

нийцэж, ногдуулах хариуцлага нь үйлдэлд нь тохирсон байх журмыг баримтлах нь зүйтэй гэж үздэг. Түүнчлэн тухайн гомдолтой холбоотой асуудал албан ёсоор шийдэгдэх хүртэл маргаж буй шийдвэр, үйл ажиллагаа хүчинтэй байдаг.

Иймээс сонгуулийн хуульд сонгуулийн маргаан шийдвэрлэх дараах зарчмыг тайлбартайгаар нарийвчлан оруулах нь зүйтэй гэж үзэж байна:

а/Гомдлыг хуульд заасан хугацаанд гаргах зарчим

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо бүрт сонгуулийн байгууллагаас гаргасан дүрэм, журам, шийдвэрт хуульд заасан хугацаанд гомдол гаргаагүй тохиолдолд түүнд гомдол гаргах эрхгүй бөгөөд уг шийдвэр, журмыг хууль ёсны эсэхийг хянахгүй гэсэн зарчмыг удирдлага болгодог. Үүний үр дүнд сонгуулийн үе шатыг тодорхой болгон эцэслэж, үр дүнд нь нэгдсэн дүгнэлт хийж, дараагийн сонгуулийн шатанд шилжих боломжийг хангадаг. Ингэснээр сонгуулиас хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа ямар нэг шийдвэр, үйл ажиллагааны хүчинтэй эсэх талаар ямар нэгэн маргаан үүсдэггүй.

б/Гомдлыг шийдвэрлэхдээ тухайн үйлдэл, үйл ажиллагааны хэрэгжилтийг хүчингүй болгон түдгэлзүүлэхгүй байх зарчим

Сонгуулийн үр дүнд байгуулагддаг аливаа төрийн байгууллагууд нь хуульд заасан сонгуулийн хугацаанаас шалтгаалж бүрэн эрх нь эхэлж, дуусгавар болдог учраас сонгуулийн ажиллагааг тасалдуулж болдоггүй, түүнийг нэгэнт эхлүүлсэн бол заавал дуусгах шаардлага байдаг. Түүнчлэн улс даяар өрнөж буй сонгууль нь товлосон хугацаанд нэгэн зэрэг эхэлж, дуусах хуульзүйн шаардлага байдаг байна.

Иймд маргаан бүхий шийдвэр, үйл ажиллагааг маргаан албан ёсоор шийдвэрлэгдэх хүртэл түдгэлзүүлэхгүй байх зарчмыг сонгуулийн хуульд оруулах шаардлагатай.

ЗУРГАА.СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ САНАЛ

Судалгааны хүрээнд хийгдсэн УИХ, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн талаархи хууль тогтоомжид тусгагдсан сонгуулийн маргаантай асуудлыг шийдвэрлэх эрхзүйн зохицуулалт болон гарсан маргаан хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаархи судалгаа, түүнд өгсөн үнэлэлт, дүгнэлтэн дээр үндэслэн энэхүү саналыг гаргаж байна.

Судалгаанаас харахад тухайн сонгуульд оролцож байгаа оролцогчдийн тооноосоо шууд пропорцианаль хамааралтайгаар сонгуулийн маргаан өрнөдөг байна. Өөрөөр хэлбэл орон нутгийн сонгууль нь хамгийн олон нэр дэвшигч, оролцогчтой сонгууль байдаг утгаараа нэр дэвшигч тус бүрийн субектив эрх хөндөгдөж, тэдгээрийн зүгээс хамгийн ихээр сонгуулийн маргааныг өрнүүлдэг байна. Үүний УИХ-ын сонгуулийг дурдаж болно. Харин Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд сонгуулийн маргаан тэр бүр гараад байдаггүй байна.

Сонгуулийн маргааныг үр дүнтэй, шударгаар, хуулийн хүрээнд түргэн шуурхай шийдвэрлэх үр нөлөө бүхий санал гаргахад сонгуулийн маргааныг агуулга нь болон хэлбэрийн талаас нь ангилж үзсэний үндсэн дээр үр нөлөө бүхий санал гаргах шаардлагатай.

Сонгуулийн маргааныг:

- цаг хугацааны байдлаар нь сонгуулийн өмнө шийдвэрлэх, дараа шийдвэрлэх маргаан;
- эрхзүйн үр дагавараар нь сонгуулийн үр дүнд нөлөөлөх, үл нөлөөлөх;
- маргааны зорилгоор нь зөрчигдсэн эрхийг сэргээх, хариуцлага тооцуулах;
- маргаан гарах үндэслэлээр нь сонгуулийн байгууллага, албан тушаалтан болон сонгуульд орологч этгээдүүдийн хууль зөрчсөн буруутай үйл ажиллагааны улмаас үүсэх маргаан;
- агуулгаар нь сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон маргаан болон иргэний сонгох, сонгогдох эрхийн зөрчилтэй холбогдсон маргаан.

1. Судалгаанаас үзэхэд сонгуулийн маргааныг үр дүнтэй шийдвэрлэх чухал асуудлын нэг нь маргаан үүсэхгүй байх нөхцөл байдлыг хангах асуудал байна.

Үүнд:

- Эрхзүйн актад тус туссан хэм хэмжээний тусгалыг хоёрдмол утгагүйгээр томьёолж, хоёр ба түүнээс дээш этгээд тухайн эрхзүйн нэг хэм хэмжээг өөр өөрөөр тайлбарлах, мэтгэлцэх байдалд хүргэхгүй байх.
- Сонгууль зохион байгуулж байгаа аливаа сонгуулийн байгууллага

албан тушаалтныг сонгуулийн эрхзүй, сонгуулийн хууль тогтоомжийн талаар сургах, мэргэшүүлэх, нэгдсэн ойлголттой болгох.

- Гарч болзошгүй маргааныг нэрлэн зааж, хэрхэн яаж шийдвэрлэх талаар тодорхой хуульчлах.

2.Маргаан үүссэн тохиолдолд маргааныг түргэн шуурхай, ил тод, шударга, үр нөлөөтэй шийдвэрлэх асуудал.

а/Үндсэн хуулийн цэцийн 2006.05.31.-ны өдрийн №5 дүгнэлтийн үндэслэх хэсэгт "... Аливаа парламентын сонгууль улс даяар нэгэн зэрэг эхэлж товлосон цагт дуусгавар болдог нийтлэг зүй тогтолтой. Энэ нь сонгуулийн холбогдолтой аливаа маргааныг сонгууль явуулж дуустал шүүх болон хөндлөнгийн ямар нэг өөр байгууллага авч хэлэлцдэггүй журамтай байна..." гэж дүгнэжээ. Үүнээс үзэхэд сонгууль явуулж дуустал аливаа сонгуулийн маргааныг шүүх болон энэ төрлийн ямар нэг байгууллага шууд оролцож шийдвэрлэх боломж нь хязгаарлагдмал байна.

Энэ үүднээс өөрийн орны процессийн эрхзүйн тогтолцоонд нийцүүлж, сонгуулийн маргааныг шүүхээс өмнө урьдчилан шийдвэрлэдэг механизмыг хуульчилж сонгуулийн хуульд тусгах нь зүйтэй тул энэ асуудлаар дараах саналыг гаргаж байна.

- Сонгуулийн байгууллагын тогтолцоонд сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий байгууллагыг бий болгон сонгуулийн маргааныг шийдвэрлүүлэх, түүний бүрэлдэхүүнд мэргэшсэн хуульчдыг багтаах.

- Сонгуулийн маргаан урьдчилан шийдвэрлэх байгууллагын шийдвэрийг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шууд анхан шатны журмаар, хяналтын шатны шүүх давж заалдах журмаар эцэслэн шийдвэрлэдэг байх.

б/Хөөн хэлэлцэх хугацааны хувьд:

- Сонгуулийн холбогдолтой гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг тодохой болгож, хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн тохиолдолд гомдол, саналыг хүлээн авдаггүй байх.

- Маргааныг шүүхийн өмнө болон шүүхийн шатанд шийдвэрлэж дуусгах цаг хугацааг тодорхой байдлаар хуульчлах.

- Сонгуулийн өмнө шийдвэрлэж дуусгах шаардлагатай маргааны хугацааг багасгаж, тодорхой болгох. /Тухайлбал нэр дэвшигч, нам, эвслийн бүртгэлийн маргаан ба энэ нь саналын хуудас хэвлэгдэхээс өмнө шийдвэрлэгдсэн байх шаардлагатай/

в/Сонгуулийн маргааныг үр дагавараар нь сонгуулийн дүнд нөлөөлөх буюу сонгуулийг хүчингүй болгох үр дагавартай маргаан, сонгуулийн үр дүнд үл нөлөөлөх буюу сонгуулийг хүчингүй болгохгүй үр дагавартай маргаан тус бүрээр ангилж заах. /Тухайлбал сонгуулийн нэг тойрогт 100-н сонгогч хууль бусаар саналаа гаргаж чадаагүй

боловч сонгуулийн ялагч, ялагдагч нарын хоорондын саналын зөрүү 1000 байгаа тохиолдолд тухайн зөрчил нь сонгуулийг хүчингүй болгох үр дагаварт хүргэхгүй. гм/

ДОЛОО.СОНГУУЛИЙН ЗӨРЧИЛ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ ХУУЛИЙН ТӨСЛИЙН САНАЛ

“... ДУГААР БҮЛЭГ

ЗӨРЧИЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Нэгдүгээр дэд бүлэг.Өргөдөл, гомдол гаргах

... дугаар зүйл.Өргөдөл, гомдол гаргах эрх

1.Сонгууль зохион байгуулах үйл явц, үйл ажиллагаатай холбогдуулан аливаа этгээд зохих шатны сонгуулийн байгууллагад өргөдөл, гомдол гаргах эрхтэй.

2.Сонгуулийн байгууллагын хууль бус шийдвэр, үйл ажиллагаа /цаашид шийдвэр гэх/-ны улмаас эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолоо зөрчигдсэн гэж үзсэн аливаа этгээд нь сонгуулийн хууль тогтоомж зөрсчөн асуудлаар сонгуулийн маргаан таслах байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

3.Өргөдөл, гомдол гаргагч нь сонгуулийн маргаан таслах байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй.

4.Хуулийн этгээдийн салбар байгууллага өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбогдуулан төв байгууллагын итгэмжлэлгүйгээр сонгуулийн маргаан таслах байгууллагад өргөдөл, гомдол гаргах эрхтэй.

... дугаар зүйл.Өргөдөл гомдол гаргах

1.Сонгуулийн байгууллагын шийдвэр нээлттэй ил тод байх бөгөөд гарсан өдрөөс нь хойш долоо хоногийн дотор өргөдөл, гомдол гаргана.

2.Хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг хүлээн авахгүй.

3.Сонгуулийн байгууллагад гаргах өргөдөл, гомдолд дараах мэдээллийг тусгах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй бол хүлээн авахаас татгалзана:

1.өргөдөл, гомдол гаргасан хүний овог нэр;

2.шуудангийн хаяг;

3.холбоо барих гурваас хоёроос доошгүй утасны дугаар /өөрийн болон дамжуулан холбоо барьж болох холбоотой этгээдийн/ ;

4.цахим хаягтай бол цахим хаяг;

5.өөрийг нь төлөөлөх төлөөлөгч томилсон бол төлөөлөгчийн нэр;

6.хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, өргөдөл, гомдолд гарын үсэг зурсан хүний албан тушаал;

4.Өргөдөл, гомдолд түүнийг гаргах үндэслэл түүний нотолгоо, баримт түүнчлэн юу шийдвэрлүүлэхийг хүсч байгаа талаархи шаардлагыг тусгасан байна.

5.Цаг хугацаа, орон зайнаас хамаарч өргөдөл, гомдлыг факсаар илгээж болно.

Хоёрдугаар дэд бүлэг.Өргөдөл, гомдол шийдвэрлэх

... дүгээр зүйл.Өргөдөл, гомдол шийдвэрлэх

1.Сонгууль зохион байгуулах үйл явц, үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авсан зохих шатны сонгуулийн байгууллага өөрийн эрх хэмжээний асуудал мөн бол 3 хоногийн дотор шийдвэрлэнэ.

2.Сонгуулийн орон нутгийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн талаар гаргасан өргөдөл, гомдлыг тухайн аймаг дахь сонгуулийн маргаан таслах орон нутгийн комисс хүлээн авч 3 хоногийн дотор шийдвэрлэнэ.

3.Сонгуулийн төв байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн талаар гаргасан өргөдөл, гомдлыг сонгуулийн маргаан таслах ерөнхий комисс хүлээн авч 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

4.Сонгуулийн маргаан таслах орон нутгийн комиссын шийдвэр сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн талаар гаргасан гомдлыг сонгуулийн маргаан таслах ерөнхий комисс хүлээн авч 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

5.Сонгуулийн маргаан таслах ерөнхий комиссын шийдвэр нь хуульд нийцээгүй гэж үзвэл гарсан өдрөөс нь хойш 7 хоногийн дотор эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолоо зөрчигдсэн гэж үзэж байгаа иргэн, хуулийн этгээд захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар гомдол гаргана.

6.Сонгуулийн маргаан таслах ерөнхий комиссын шийдвэрийн талаар гомдол

хүлээн авсан шүүх 3 хоногийн дотор захиргааны хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх ба захиргааны хэрэг үүсгэсэн бол ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

7. Сонгуулийн маргаан таслах ерөнхий комиссын шийдвэрийн талаар гомдол хүлээн авсан шүүх захиргааны хэрэг үүсгэхээс татгалзсан бол татгалзах болсон үндэслэл, шалтгааныг дурдаж буцаах ба уг шийдвэрт гомдол гаргахгүй.

8. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр сонгуулийн хууль тогтоомжид нийцээгүй гэж үзвэл гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор улсын дээд шүүхэд гомдол гаргах ба гаргасан гомдлыг 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

9. Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий этгээд нь тухайн маргаантай асуудлыг шийдвэрлэсэн өдрөөс хойш 3 хоногийн дотор бичгээр хэлбэржүүлж гаргах ба гаргасан даруй холбогдох этгээдэд мэдэгдэнэ.

10. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрийг холбогдох этгээд өөрийн биеэр эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан хүлээн авна.

11. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн сонгуулийн маргаан таслах байгууллагын шийдвэр нь дор дурдсан агуулгатай байна:

1. сонгуулийн байгууллагын шийдвэрийг хүчингүй болгох;
2. сонгуулийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар тодорхой шийдвэр гаргахыг сонгуулийн байгууллагад даалгах;
3. гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгох.

12. Сонгуулийн маргаан таслах байгууллагаас сонгуулийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар тодорхой шийдвэр гаргахыг сонгуулийн байгууллагад даалгасан бол уг шийдвэрийг биелүүлэх хугацаа, яаж биелүүлэх арга замыг заана.

13. Сонгуулийн маргаан таслах комиссын шийдвэрийг сонгуулийн сонгуулийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

14. Шүүх сонгуулийн маргаан таслах байгууллагын шийдвэрийг хүчингүйд тооцсон эсхүл илт хууль бус гэж шийдвэрлэсний улмаас дахин сонгууль, дахин санал хураалт явагдах нөхцөл байдал үүссэн бол шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн шатны сонгуулийн байгууллага шийдвэр гаргана.

15. Захиргааны хариуцлага хүлээлгэхээр заасан сонгуулийн хууль тогтоомж зөрчигдсөн талаархи маргааныг сонгуулийн маргаан таслах байгууллага эхэлж шийдвэрлэхгүй бөгөөд захиргааны зөрчил шийдвэрлэх журмаар шийдвэрлэгдсэний дараа тухайн маргаантай асуудлыг шийдвэрлэнэ.

Гурвадугаар дэд бүлэг.Зөрчил шийдвэрлэх үйл ажиллагаа

... дугаар зүйл.Зөрчил шийдвэрлэх

1.Энэ хуульд заасан захиргааны зөрчил үйлдэгдсэн талаар сонирхогч этгээд аймаг, дүүргийн цагдаагийн байгууллагад, түүнчлэн сум, сум дундын шүүхийн шүүгч, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид гомдол, мэдээлэл гаргаж болно.

2.Энэ хуулиар захиргааны хариуцлага хүлээлгэхээр заасан зөрчлийг цагдаагийн байгууллага шалгаж, сум, сум дундын шүүхийн шүүгч, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч хянан шийдвэрлэнэ.

3.Захиргааны зөрчлийн асуудлаар шууд шүүгчид гомдол, мэдээлэл ирсэн бол шүүгч шууд хянан шийдвэрлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл тухайн зөрчилтэй асуудлыг шалгуулахаар өргөдөл, гомдлыг аймаг, дүүргийн цагдаагийн хэлтэс шилжүүлнэ.

4.Захиргааны зөрчлийг шалгах, шийдвэрлэх үйл ажиллагаанд Захиргааны хариуцлагын тухай хуулийг баримтлана.

5.Захиргааны хариуцлага хүлээсэн нь тухайн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөлөх үндэслэл болохгүй.”

Хавсралт 1

№	Шийдвэрүүд...	Тайлбар
---	---------------	---------

1	<p>Булган аймаг дахь сум дундын шүүхийн 2008.10.16-ны өдрийн №480 шийдвэр, Булган аймгийн давж заалдах шатны шүүхийн №35 магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүхийн 2009.01.29-ний №64 тогтоол.</p>	<p>УИХ-ын 2008 оны сонгуулийн 4-р тойрогт үүссэн маргаантай асуудал. Агуулга нь 4-р тойргийн хорооны хуралдаанаар шийдвэрлэсэн шийдвэрийг тойргийн хорооны дарга дур мэдэн өөрчилсөнтэй холбоотой маргаан.</p> <p>Уг маргааныг ерөнхий харьяаллын дагуу хүлээн авч хэрэг үүсгэн авч хэлэлцсэн боловч эцсийн дүндээ шүүхээс урьдчилан шийдвэрлэх журам зөрчсөн гэж үзэн нэхэмжлэлийн хүлээн авахаас татгалзаж, хэргийг / нэхэмжлэлийг бус/ хүлээн авахаас татгалзжээ.</p> <p>Маргаан 2008 оны 07-р сараас 2009 оны 01-р сар хүртэл үргэлжилжээ.</p>
---	--	--

2	<p>Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн 2008.08.12-ны өдрийн №2188 захирамж</p> <p>Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн 2008.09.05-ны өдрийн №2427 захирамж</p> <p>Чингэлтэй дүүргийн шүүхийн 2008.09.12-ны өдрийн №27 тогтоол</p> <p>Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн 2008.09.08-ны өдрийн №868 шүүгчийн захирамж</p> <p>Улсын дээд шүүхийн давж заалдах шүүх хуралдааны 2008.09.16-ны өдрийн №223 магадлал</p> <p>Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн 2008.09.08-ны өдрийн №938 шүүгчийн захирамж</p> <p>Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2008.08.12-ны өдрийн №90 Цэцийн гишүүний тогтоол</p> <p>Үндсэн хуулийн цэцийн 2008.10.03-ны өдрийн №15 Цэцийн магадлал</p> <p>Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2008.10.23-ны өдрийн №119 Цэцийн гишүүний тогтоол</p> <p>Үндсэн хуулийн цэцийн 2008.12.29-ны өдрийн №21 Цэцийн магадлал</p> <p>Улсын дээд шүүхийн 2008.10.21-ний өдрийн 1/3009 албан тоот</p> <p>Үндсэн хуулийн цэцийн 2008.10.23-ны өдрийн №3/284 албан тоот</p> <p>Улсын дээд шүүхийн 2008.11.05-ны өдрийн №3/3197 албан тоот</p> <p>Чингэлтэй дүүргийн шүүхийн 2009.01.05-ны өдрийн №49 шүүхийн шийдвэр</p> <p>Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2009.03.06-ны өдрийн №163 магадлал</p> <p>Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны №188 тогтоол</p>	<p>УИХ-ын сонгуулийн 2008 оны сонгуулийн 24 тойрогт үүссэн маргаантай асуудал.</p> <p>Санал буруу тоолсон, СЕХ-ны дарга хууль зөрчсөн тухай маргаан.</p> <p>Санал буруу тоолсонтой холбоотой маргааныг ерөнхий харьяаллын шүүх, захиргааны хэргийн шүүх, Үндсэн хуулийн шүүхийн аль нь ч хүлээн аваагүй байна.</p> <p>Харин СЕХ-ны даргын хууль бус үйл ажиллагаатай холбоотой маргааныг аль ч шүүх хүлээн авахгүй байсан нь Үндсэн хуулийн шүүхээр “хэргийн харьяалал” тогтоолгох дээрээ “тулж” улмаар Улсын дээд шүүхийн иргэний танхимын тэргүүн шүүгч шийдвэрлэснээр ерөнхий харьяаллын шүүх хүлээн авч шийдвэрлэсэн байна.</p> <p>Маргаан нэхэмжлэгч талд ашигтай шийдэгдсэн боловч ямар нэг эрхзүйн үр дагаварт хүрээгүй ажээ.</p> <p>Маргаан 2008 оны 07-р сараас 2009 оны 04-р сар хүртэл 9 сар үргэлжилжээ.</p>
---	--	--

3	<p>Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн 2010.07.26-ны өдрийн №3847 захирамж</p> <p>Чингэлтэй дүүргийн шүүхийн 2010.08.06-ны өдрийн №23 тогтоол</p> <p>Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн 2010.08.13-ны өдрийн №4074 захирамж</p> <p>Чингэлтэй дүүргийн шүүхийн 2010.08.26-ны өдрийн №24 тогтоол</p> <p>Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн 2010.08.23-ны өдрийн №4203 захирамж</p> <p>Чингэлтэй дүүргийн шүүхийн 2010.10.26-ны өдрийн №1565 шүүхийн шийдвэр</p>	<p>УИХ-ын 2009 оны нөхөн сонгуулийн 24-р тойрогт үүссэн маргаантай асуудал.</p> <p>Сонгогчдын нэрийн жагсаалтаас их хэмжээний сонгогчийн хууль бусаар хассан эсэхтэй холбогдсон маргаан.</p> <p>Маргааныг мөн л шүүх хүлээн авахаас татгалзсан байна.</p> <p>Маргааны агуулгаас шалтгаалан “даамжран” төрийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдлоо шийдүүлж чадаагүй тухайн маргаан болж өөрчлөгдсөн байна.</p>
4	<p>Баянхонгор аймгийн захиргааны хэргийн шүүхийн 2012.06.18-ны өдрийн №22 захирамж..</p> <p>Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2012.07.05-ны өдрийн №131 шүүхийн тогтоол</p>	<p>УИХ-ын 2012 оны сонгуулийн 3-р тойрогт үүссэн маргаантай асуудал.</p> <p>Нэр дэвшигч сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн эсэх, түүнийг нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасуулахтай холбогдсон маргаан.</p> <p>Захиргааны хэргийн шүүх “нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй этгээд” үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан.</p>

5	<p>Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн 2012.07.16-ны өдрийн 1124 шүүгчийн захирамж.. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2012.07.26-ны өдрийн №145 тогтоол Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2012.11.29-ний өдрийн №488 шийдвэр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2013.01.17-ны өдрийн №37 магадлал Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2013.03.04-ний өдрийн №40 тогтоол</p>	<p>УИХ-ын 2012 оны сонгуулийн 26-р тойрогт үүссэн маргаантай асуудал.</p> <p>Сонгуулийн дүн буруу гаргасан эсэхтэй холбогдсон маргаан.</p> <p>Уг асуудлыг захиргааны хэргийн шүүх эхлээд хүлээн авахаас татгалзсан боловч давж заалдах шатны шүүх хүлээн авахаар шийдсэн байна. Маргаан 2012 оны 07-р сараас 2013 оны 03-р сар хүртэл 8 сар үргэлжилжээ.</p>
6	<p>Увс аймгийн захиргааны хэргийн шүүхийн 2012.11.22-ний өдрийн №24 шийдвэр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2013.01.16-ны өдрийн №32 магадлал Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2013.04.01-ний өдрийн №61 тогтоол</p>	<p>2012 оны УИХ-ын сонгуулийн 15 дугаар тойрогт үүссэн маргаантай асуудал.</p> <p>Нэр дэвшигч сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тул түүнийг нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасуулахтай холбогдсон маргаан.</p> <p>Захиргааны хэргийн шүүх хүлээн авч хэлэлцсэн боловч тухайн маргаантай асуудлыг шийдвэрлэх эрх хэмжээг захиргааны хэргийн шүүхэд хуулиар олгоогүй байна гэж үзэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.</p> <p>Маргаан 2012 оны 07-р сараас 2013 оны 04-р сар хүртэл 9 сар үргэлжилжээ.</p>

7	<p>Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2013.05.08-ны өдрийн №42 тогтоол</p> <p>Үндсэн хуулийн цэцийн 2013.06.19-ний өдрийн №13 магадлал</p>	<p>УИХ-ын 2012 оны сонгуулийн 26 дугаар тойрогт дахин санал хураалт явуулахтай холбодсон маргаан.</p> <p>Сонгуулийн хороо санал хурааж дуусах цагаас өмнө санал хурааж дууссантай холбоотой маргаан.</p> <p>Уг асуулыг Үндсэн хуулийн цэц хүлээн авч хууль /Үндсэн хууль?/ зөрчөөгүй гэж үзэн маргаан үүсгэхээс татгалзсан байна.</p>
8	<p>Хөвсгөлаймгийн захиргааны хэргийн шүүхийн 2013.09.04-ний өдрийн №28 шийдвэр</p> <p>Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2013.05.15-ны өдрийн №151 магадлал</p>	<p>Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2012 оны сонгуулиар үүссэн маргаантай асуудал.</p> <p>Сонгууль оролцогч нам сонгуулийн хууль зөрчсөн мөрийн хөтөлбөртэйн улмаас тухайн намыг намын жагсаалтаас хасуулахтай холбогдсон маргаан.</p> <p>Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулий тухай хуульд заасны дагуу захиргааны хэргийн шүүх хүлээн авч шийдвэрлэсэн байна.</p> <p>2012 оны 12 дугаар сараас өнөөдрийг хүртэл дуусаагүй байгаа.</p>

9	<p>Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2012.12.04-ний өдрийн №0498 шийдвэр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2013.01.23-ны өдрийн №42 магадлал Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2013.04.01-ний өдрийн №59 тогтоол</p>	<p>Нийслэлийн Баянгол дүүргийн ИТХ-ын 2013 оны сонгуулиар үүссэн маргаантай асуудал.</p> <p>Нэр дэвшигч хуульд шаардлага хангасан эсэхтэй холбогдсон маргаан.</p> <p>Маргааныг захиргааны хэргийн шүүх Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулий тухай хуульд заасны дагуу хүлээн авч шийдвэрлэсэн байна.</p> <p>2012 оны 12 дугаар сараас 2013 оны 04-р сар хүртэл 4 сар үргэлжилжээ.</p>
10	<p>Говь-Алтай аймгийн захиргааны хэргийн шүүхийн 2012.10.08-ний өдрийн №08 шийдвэр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2012.11.20-ны өдрийн №337 магадлал Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2013.01.14-ний өдрийн №13 тогтоол</p>	<p>Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2012 оны сонгуулиар үүссэн маргаантай асуудал.</p> <p>Намыг бүртгээгүйтэй холбогдсон маргаан.</p> <p>Маргааныг захиргааны хэргийн шүүх Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд заасны дагуу хүлээн авч шийдвэрлэсэн байна.</p> <p>2012 оны 12-р сараас 2013 оны 04-р сар хүртэл 5 сар үргэлжилжээ.</p> <p>Сонгууль болоод нэг жил өнгөрсний дараа дахин сонгууль явагдах гэж байна.</p>

11	<p>Говь-Алтай аймгийн захиргааны хэргийн шүүхийн 2013.04.10-ний өдрийн №06 шийдвэр</p> <p>Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2013.06.13-ны өдрийн №180 магадлал</p> <p>Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2013.09.23-ний өдрийн №144 тогтоол</p>	<p>Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2012 оны сонгуулиар үүссэн маргаантай асуудал.</p> <p>Намыг бүртгэлгүйгээр сонгууль явуулсан тул дахин сонгууль явуулахтай холбогдсон маргаан.</p> <p>Маргааныг захиргааны хэргийн шүүх Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулий тухай хуульд заасны дагуу хүлээн авч шийдвэрлэсэн байна.</p> <p>2013 оны 04-р сараас 2013 оны 09-р сар хүртэл 5 сар үргэлжилжээ.</p> <p>Сонгууль болоод нэг жил өнгөрсний дараа дахин сонгууль явагдах гэж байна.</p>
12	<p>Говь-Сүмбэр аймгийн захиргааны хэргийн шүүхийн 2013.08.09-ний өдрийн №10 шийдвэр</p> <p>Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2013.10.02-ны өдрийн №312 магадлал</p> <p>Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2013.12.02-ний өдрийн №228 тогтоол</p>	<p>Говь-Сүмбэр аймгийн ИТХ-ын 2012 оны сонгуулиар үүссэн маргаантай асуудал.</p> <p>Нөхөн сонгууль явуулахтай холбогдсон маргаан.</p> <p>Маргааныг захиргааны хэргийн шүүх Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулий тухай хуульд заасны дагуу хүлээн авч шийдвэрлэсэн байна.</p> <p>Шүүхийн шийдвэрт зааснаар нөхөн сонгууль явагдана.</p> <p>Ээлжит сонгууль явагдаад 1 жил өнгөрсний дараа нөхөн сонгууль явагдахаар шийдэгдсэн ба хэзээ явагдах нь тодорхойгүй.</p>